



ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЙЛАН 2024 ОН





ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЙЛАН

(2024 ОН)

АГУУЛГА

ТАНИЛЦУУЛГА	3
Товчилсон үгийн жагсаалт	4
Зураг, хүснэгтийн жагсаалт	5
МЭДЭГДЭЛ	6
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛ	7
Бүлгийн дүгнэлт	16
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	17
1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	18
2.Хохирогч хамгаалал	34
3.Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа	40
4.Хамтын ажиллагаа	55
Бүлгийн дүгнэлт	62
ЗӨВЛӨМЖ	64



ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төсөл тав дахь жилдээ хэрэгжиж байна.


Төслийн зорилго нь хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч төвтэй арга барилыг нэвтрүүлэх, гэмт этгээдүүдэд зохих ял шийтгэл оногдуулж, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулж чадавхыг бэхжүүлэхэд оршино.

Төслийн хүрээнд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажиллаж байгаа байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох явцыг сайжруулах, үйл ажиллагааг уялдуулах, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах тогтолцоог бэхжүүлэх зорилгоор мэдээлэлд суурилсан “Хүн худалдаалахтай тэмцэх нөхцөл байдлын тайлан”-г жил бүр боловсруулж, холбогдох талуудад түгээхээр төлөвлөсөн.

Энэ хүрээнд “Хүн худалдаалахтай тэмцэх нөхцөл байдлын тайлан” 2019-2021, 2022-2023 судалгааны тайлангуудыг боловсруулан нийтийн хүртээл болгож байсан бол энэ удаагийн тайлангаар 2024 онд хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогч хамгаалал, хамтын ажиллагаанд гарсан ололт амжилт, анхаарах асуудлыг хөндөн авч үзлээ.

Хүн худалдаалахтай тэмцэх нөхцөл байдлын тайланг “4Р” буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хохирогч хамгаалал, урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааны хүрээнд мэдээлэлд суурилсан боловсруулж, тодорхой дүгнэлт, санал, зөвлөмж өгөхийг зорилоо.

Зураг 1. Судалгааны арга зүй



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУБ	Олон улсын байгууллага
Палермогийн протокол	Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол
ТББ	Төрийн бус байгууллага
ХБНГУ	Холбооны бүгд найрамдах Герман улс



ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Хохирогчдын хувийн байдал	25
Хүснэгт 2.	Шүүхээс гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ял оногдуулсан байдал	31
Хүснэгт 3.	Аяллаа зогсоосон шалтгаан (давхардсан тоогоор)	49
Хүснэгт 4.	Тоон мэдээлэл	54
Зураг 1.	Судалгааны арга зүй	3
Зураг 2.	Хэргийн шийдвэрлэлт /зүйлчлэлээр/	19
Зураг 3.	Шалгагдаж буй нийт хэргийн зүйлчлэл	19
Зураг 4.	2024 онд бүртгэгдсэн гэмт хэргийн зүйлчлэл	19
Зураг 5.	Гомдол, мэдээллийг бүртгэсэн байдал	20
Зураг 6.	Нийслэлийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэргийн байршил	21
Зураг 7.	2024 онд шинээр яллагдагчаар татсан хүний тоо	22
Зураг 8.	Яллагдагчаар татагдсан хүмүүсийн насны байдал	22
Зураг 9.	Яллагдагчаар татагдсан хүмүүсийн хүйсийн байдал	23
Зураг 10.	Яллагдагчаар татагдсан хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн байдал	23
Зураг 11.	Яллагдагчаар татагдсан хүмүүсийн ял шийтгэгдсэн байдал	23
Зураг 12.	2024 онд хохирогчоор тогтоогдсон хүний тоо /хэргийн зүйлчлэлээр/	24
Зураг 13.	Өмгөөлүүлэх эрхийн хэрэгжилт	27
Зураг 14.	Хааж шийдвэрлэсэн хэргийг зүйлчлэл, үндэслэлээр харуулбал,	29
Зураг 15.	Үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандсан хохирогч/үйлчлүүлэгчдийн тоон мэдээлэл /жилээр/	34
Зураг 16.	Хохирогч/үйлчлүүлэгчдийн тоо, байгууллагаар	35
Зураг 17.	Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн байдал	35
Зураг 18.	Хамгаалах байраар үйлчлүүлсэн хохирогч/үйлчлүүлэгч, байгууллагаар	36
Зураг 19.	Хохирогч/үйлчлүүлэгчдэд үзүүлсэн үйлчилгээний төрөл, байгууллагаар	37
Зураг 20.	Хамгаалах байрны зардлын тооцоо	38
Зураг 21.	Улсын хилээр гарах чиглэлд нэвтэрсэн хүүхдийн тоо	47
Зураг 22.	Чингис хаан боомт дээр асуумж авсан иргэдийн насны байдал	48
Зураг 23.	Хөх зүрхний аян	52
Зураг 24.	Зөвлөх үйлчилгээний үеийн мэдээлэл	52
Зураг 25.	Чиглүүлэгч багш нарт зориулсан гарын авлага	54
Зураг 26.	Сургагч багш нарын сургалт	54
Зураг 27.	Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд	55

МЭДЭГДЭЛ

Энэхүү “Хүн худалдаалахтай тэмцэх нөхцөл байдлын тайлан (2024)”-г Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт:

Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэв.

Тайланд дурдагдсан үзэл бодол, үр дүн, мэдээлэл, дүгнэлт нь зөвхөн зохиогчийнх бөгөөд Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын болон Азийн сангийн үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

СУДАЛГААНЫ БАГ

Г.ЗОЛЗАЯА

Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор;

Г.АМАРЖАРГАЛ

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны ахлах мэргэжилтэн бөгөөд Салбар дундын хамтарсан багийн ахлагч;

Т.ЦОГЗОЛМАА

Хүйсийн тэгш эрх төв төрийн бус байгууллагын хөтөлбөрийн ажилтан бөгөөд Салбар дундын хамтарсан багийн гишүүн.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ



**ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ
ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН
ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛ

1. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотойгоор Эрүүгийн хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлт

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн чуулганы хуралдаанаас Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, уг нэмэлт, өөрчлөлтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж байна.

Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн ялын бодлогод дараах өөрчлөлтүүд тусгагдлаа. Үүнд:

- Эрүүгийн хуулийн **12.1 дүгээр зүйл (хүчиндэх)-ийн 3 дахь хэсэг, 12.3 дугаар зүйл (бэлгийн мөлжлөг)-ийн 2.1, 3.2 дахь заалт, 13.1 дүгээр зүйл (хүн худалдаалах)-ийн 2.1 дэх заалтад** заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож, хохирогчийг арван найман насанд хүрсний дараа тоолж эхлэхээр,
- Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, **12.1 дүгээр зүйл (хүчиндэх)-ийн 4 дэх хэсэг, 12.3 дугаар зүйл (бэлгийн мөлжлөг)-ийн 4.1 дэх заалт, 13.1 дүгээр зүйл (хүн худалдаалах)-ийн 2, 3 дахь хэсэг, 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт** заасан гэмт хэрэг үйлдсэн ялтныг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохгүйгээр,
- Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, **12.1 дүгээр зүйл (хүчиндэх)-ийн 4 дэх хэсэг, 12.3 дугаар зүйл (бэлгийн мөлжлөг)-ийн 4.1 дэх заалт, 13.1 дүгээр зүйл (хүн худалдаалах)-ийн 2, 3 дахь хэсэгт** заасан гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй байхаар тус тус заасан байна.

2. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга ба хүн худалдаалахтай тэмцэх эрх зүйн орчны өөрчлөлт

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы хуралдаанаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон хамт өргөн мэдүүлсэн хуулиудыг баталсан.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд дараах нэмэлт, өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4 дэх заалтад “хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг батлах”;



- Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.5 дахь заалтад “хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх салбар дундын хамтарсан багийг байгуулж, ажиллах журмыг батлах”
- 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэгт “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байрны стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална” гэсэн заалт нэмэгдэж,
- Хуулийн 5 дугаар зүйлийн 5.11 дэх хэсгийг “Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй хүүхдийг илрүүлэх, хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж, сургалт, судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хэсэгт заасан чиг үүргийг гүйцэтгэхдээ магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдтэй хамтран ажиллаж болно» гэж өөрчлөн найруулжээ.

3.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн 2023 онд хийсэн бөгөөд үр дүнг тоймлон авч үзвэл:

1. НҮБ-ын “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц болон түүний нэмэлт протоколд Монгол Улс 2008 онд нэгдэн орсон боловч албан ёсоор Төрийн мэдээлэл сэтгүүл болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд нийтлээгүй нь Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж, иргэдийн мэдээлэл авах боломжийг хязгаарлаж байгаад анхаарах шаардлагатай гэж,
2. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар тусгайлан журам батлах эрх олгосон субъектүүд тэдгээр журмыг өнөөдрийн байдлаар батлаагүй байгаа нь хуулийн хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байдлыг бий болгосон байна. Тухайлбал, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхэд хамаарах “Хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам”, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хувьд “Эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ хийх журам” зэргийг батлаагүй,
3. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд хохирогчийг хэрхэн тогтоох, хохирогчид хэрхэн туслалцаа үзүүлэх асуудлыг шийдвэрлэх нь чухал юм. Гэтэл Монгол Улсын хувьд хохирогч гэх ойлголтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиудаар ялгаатай байдлаар хуульчилсан нь хууль хэрэглээний хувьд төөрөгдөл үүсгэсэн зохицуулалт болсон,
4. Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хамгаалах байрны хувьд Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2013 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” стандартаар зохицуулж байгаа боловч тус стандартад нийцсэн хамгаалах байр байхгүй, хилийн чанадад хэрхэн энэ асуудлыг шийдэх төсвийн асуудлыг шийдвэрлээгүй,

5. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий Дэд зөвлөл нь хуулиар олгосон бүрэн эрхийн 50 хүрэхгүй хувийг хэрэгжүүлж ажилладаг. Шалтгаан нь тус бүрэн эрхийг хэрэгжүүлэх, хянах, зөвлөх эрх мэдэл бүхий Дэд зөвлөлийн гишүүд нь бие даасан төрийн байгууллагуудын төлөөлөл бөгөөд гаргаж байгаа шийдвэрээ хэрэгжүүлэх төсөвгүй, дэд бүтэцгүй, шийдвэр нь заавал биелэгдэх шинжгүй тул бусад байгууллагын тайлан мэдээг сонсох төдийгөөр хүн худалдаалахтай тэмцэх ажлыг хэрэгжүүлж байгаа,
6. Гэмт хэрэгтэй тэмцэхэд төрийн байгууллагуудын хэрэгжүүлж буй арга хэмжээ, чиг үүрэг нь хангалтгүй түвшинд үнэлэгдсэн бөгөөд хуулиар тусгайлсан журмаар зохицуулахаар заасан журмыг батлаагүй нь хууль практикт хэрэгжих боломжгүй байдлыг бий болгосон. Энэ нь Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлого, төлөвлөлтгүй байгаатай холбоотой байна гэж,
7. Энэ хуулийг дагаж гарсан журмын хэрэгжилт хангалтгүйн зэрэгцээ, зарим хэм хэмжээ тогтоосон актыг огт батлуулаагүй байгаа зэргийг дурдсан.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланд дурдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх, хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хуулийг дагаж батлагдах шаардлагатай зарим журмыг боловсруулах чиглэлээр 2024 онд тодорхой ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Тухайлбал,

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 215 дугаар тогтоолоор “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журам” батлагдав¹.



Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, алдар хүндийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах зорилгоор хамгаалах байр ажиллана.” гэж, мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт “Хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журмыг Засгийн газар батална.” гэж тус тус заасан боловч 2024 оныг хүртэл энэхүү журам батлагдаагүй байсан.

Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүрээнд Азийн сангийн дэмжлэгтэйгээр Хүйсийн тэгш эрх төв төрийн бус байгууллагаас энэхүү журмын төслийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлжээ.

Улмаар Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Засгийн газрын гишүүдээс санал авч нэгтгэн, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанд танилцуулан батлуулж, батлагдсан өдрөөсөө хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355372002191>



Энэхүү журам батлагдсанаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, хэвийн амьдралд нь эргэж оруулах, тэдний хөгжлийг дэмжихэд оролцож буй төрийн болон төрийн бус байгууллагууд нэгдсэн нэг стандарт, журмыг баримтлан үйл ажиллагаа явуулах, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг түр хамгаалах байрны санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, тэдний нэр төр, алдар хүндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад ахиц гарч, Монгол Улсын олон улсын гэрээгээр өөртөө хүлээсэн үүргээ биелүүлэх, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилт хангагдах ач холбогдолтой юм.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын 2024 оны А/60, А/40 дугаартай хамтарсан тушаалаар “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам” батлагдав.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалтад “Улсын ерөнхий прокурортой хамтран хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам батлах” гэж заасан боловч мөн л 2024 оныг хүртэл энэхүү журам батлагдаагүй байсан.

Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүрээнд Азийн сангийн дэмжлэгтэйгээр Хүйсийн тэгш эрх төв төрийн бус байгууллага, Хууль дээдлэх ёс, эрх зүйн хөгжлийн төв төрийн бус байгууллагын судлаачдын баг хамтран энэхүү журмын төслийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлжээ.

Улмаар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/60, А/40 дүгээр хамтарсан тушаалаар “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам”-ыг баталж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулсан.

Энэхүү журам батлагдсанаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангахдаа баримтлах зарчим, шийдвэр гаргах эрх бүхий этгээдийг тодорхойлж, тэдгээрийн авч хэрэгжүүлэх үүргийг нарийвчлан субъект тус бүрээр журамласнаар хохирогчийн эрхийг хангаж хамгаалах эрх зүйн орчин сайжирч, Монгол Улсад Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, холбогдох бусад хуулиар болон олон улсын баримт бичгээр хүлээлгэсэн үүргийг биелүүлэх нөхцөл бүрдэж байна.

Мөн хууль сахиулах байгууллагын ажилтан, алба хаагч хохирогчийг таньж тогтоох ажиллагааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/57 дугаар тушаалаар батлагдсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх заавар, асуулга”-ын дагуу явуулах эрх зүйн орчныг энэхүү журмаар тогтоож өгсөн нь сайшаалтай байна.

Улсын ерөнхий прокурорын 2024 оны А/01 тушаалаар “Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага”-ыг шинэчлэн батлагдлаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч, бусад оролцогчоос мэдүүлэг авах зорилгоор шаардлага хангасан мэдүүлэг авах өрөөг байгуулж, ашиглана.

Энэхүү өрөөг байгуулахад тавигдах шаардлагыг тодорхойлох, хуульд заасан үндэслэл, журмын дагуу мэдүүлэг авах, хүний эрхийг дээдлэх, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаанаас ангид, аюулгүй байдлыг хангах зорилгоор Улсын Ерөнхий прокурорын 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар “Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага”-ыг баталжээ.

Энэхүү шаардлага батлагдсанаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагууд мэдүүлэг авах өрөөг шинэчлэх, засварлах, шинээр байгуулах хэрэгцээг тооцжээ.

Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/40 дүгээр тушаалаар “Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам”-ыг шинэчлэн батлав.



Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт “энэ хуулийн 12.1.3-т заасан хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журмыг нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж заасны дагуу Хөдөлмөрийн сайдын 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/135 дугаартай тушаалаар “Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам”-ыг баталсан.

Энэхүү журмын зорилго нь хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах хуулийн зорилтыг хангаж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршдог.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланд дурдсанаар 2015 онд батлагдсан журмын хэрэгжилт хангалтгүй, журмыг хэрэгжүүлэхээр үүрэг болгон заасан төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг өөрчлөгдсөнөөс үүдэн журмын хэрэгжилтийн залгамж холбоо алдагдаж, цаашлаад тогтвортой хэрэгжих боломжгүй байдал үүссэн тул шинэчлэн боловсруулах шаардлагатай гэж үзсэн.

Иймд Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүрээнд Азийн сангийн дэмжлэгтэйгээр Хүйсийн тэгш эрх төв төрийн бус байгууллага, Богд судалгааны хүрээлэнтэй хамтран журмын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлжээ.

Улмаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар “Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам”-ыг баталсан байна.



Журмаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч өөрөө хүсвэл түүнийг хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамруулах, мэргэжлийн анхан шатны ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах, мэргэжлийн болон мэргэшүүлэх сургалтад хамруулах, ажлын байранд холбон зуучлах харилцааг зохицуулсан. Мөн эрх бүхий байгууллагаас хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн амь нас, эрүүл мэндэд бодитой аюул, заналхийлэл бий болсныг тогтоож Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасны дагуу оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлсэн хохирогчийн хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийг мэргэжлийн сургалтад хамруулах, эсхүл ажлын байраар хангах эрх зүйн орчин бүрдэж байна.

Гадаад харилцааны сайдын 2024 оны А/71 дүгээр тушаалаар “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам”-ыг шинэчлэн батлав.



Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт “гадаад улсад Монгол Улсыг төлөөлөн суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах үйлчилгээ үзүүлэх журмыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж заасны дагуу

Гадаад харилцааны сайдын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар “Хүн худалдаалах гэмт хэргийг хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам”-ыг баталсан.

Энэхүү журам нь хилийн чанадад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэхэд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, үйл ажиллагаанд баримтлах зарчим, хохирогчийг түр хугацаанд орон байраар хангах, баримт бичиггүй хохирогчид буцах үнэмлэх олгох, хохирогчид үйлчилгээ үзүүлэхэд гарсан зардлыг хэрхэн хариуцах талаарх харилцааг ерөнхий байдлаар зохицуулсан.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланд дурдсанаар энэхүү журмын хэрэгжилт хангалтгүй бөгөөд зарим зохицуулалтыг хууль тогтоомжид нийцүүлэх шаардлагатай тул шинэчлэн боловсруулах зөвлөмжийг өгчээ.

Иймд Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүрээнд Азийн сангийн дэмжлэгтэйгээр Хүйсийн тэгш эрх төв төрийн бус байгууллага, Богд судалгааны хүрээлэнтэй хамтран журмын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Гадаад харилцааны яаманд хүргүүлжээ.

Гадаад харилцааны яамнаас Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Консулын газар, Дипломат төлөөлөгчийн газруудад журмын төслийг хүргүүлэн санал авч нэгтгэн, улмаар Гадаад харилцааны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар баталсан.

Энэхүү журам батлагдсанаар гадаад улсад Монгол Улсыг төлөөлөн суугаа дипломат төлөөлөгчийн газраас хилийн чанадад хүн худалдаалахын хохирогч болсон Монгол Улсын иргэний аюулгүй байдлыг хангах, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түр хугацаагаар байр, хоол, хүнсээр хангах, гадаад паспорт болон түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эрүүл мэндийн болон сэтгэцийн яаралтай тусламж авахад нь туслалцаа үзүүлэх, эх оронд нь буцаан авчрах, шүүх болон бусад хууль хяналтын холбогдох байгууллагаар хэргийг шалгуулах, хянуулахад эрх ашгийг нь хамгаалах ажиллагааг үнэ төлбөргүйгээр шуурхай үзүүлэх эрх зүйн орчин бүрдлээ.

Хүн худалдаалахтай тэмцэх дунд хугацааны хөтөлбөрийн төслийг боловсруулж байна

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Засгийн газар нь хүн худалдаалахтай тэмцэх үндэсний бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтад Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилго, зорилтод нийцсэн, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлтийн баримт бичгийг хэлнэ гэжээ. Засгийн газрын 5 жилийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр нь урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилго зорилтод нийцсэн байх шаардлагатай юм.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтад заасан “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” болох УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын Хүн, нийгмийн амар тайван байдал гэсэн зүйлд 2021-2030 онд Монгол Улс үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, иргэдийг гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх тогтолцоонд инновацад суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, нөлөөллийн арга хэмжээг цогцоор хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлж, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэхийг зорьжээ. Түүнчлэн 2 дугаар хэсэгт үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үндэсний чадавхыг бэхжүүлэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ гэж, Улсын Их Хурлаас 2024 оны 08 дугаар сарын 24-ний өдөр баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Улс дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний чадавхыг дээшлүүлж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх мөрдөх албыг байгуулж мэргэшүүлж, гадаад хамтын ажиллагааг сайжруулна” гэж заасныг үндэслэн Хүн худалдаалахтай тэмцэх дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулжээ.

Хүн худалдаалахтай тэмцэх дунд хугацааны хөтөлбөрийн зорилго, зорилтыг тодорхойлохдоо “4Р”-гийн хүрээнд тодорхойлсон бөгөөд “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод заасан үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг буюу түүний нэг төрөл болох хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хохирогчийг



хамгаалах, урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх, гэмт этгээдийг яллах, цээрлүүлэх, инновацад суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж цогц арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн үндсийг тодорхойлж, хамтын ажиллагааны тасралтгүй байдлыг хангах нь энэхүү хөтөлбөрийн суурь зорилго” байхаар тодорхойлжээ.

Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд урьдчилан сэргийлэх, хохирогч хамгаалал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хамтын ажиллагааны үндсэн 4 зорилт 24 дэд зорилтыг тодорхойлсон байна.

Дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөг 2024 оны 12 дугаар сард Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэн, эдийн засгийн тооцооллыг хийн баталгаажуулах шийдвэр гаргажээ.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Тухайлбал,

- ✓ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээний мөрөөр хууль дагаж гарсан журмуудыг шинэчлэх, шинээр батлах ажлууд хийгдэж, журмууд хэрэгжиж эхэлсэн байна.
- ✓ Хүн худалдаалахтай тэмцэх дунд хугацааны хөтөлбөрийн төслийг боловсруулж, холбогдох талуудаар хэлэлцүүлжээ.
- ✓ Эрүүгийн хуульд хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлого өөрчлөгдөж, хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллахгүй, өршөөл үзүүлэхгүй байх хуулийн зохицуулалттай болсон нь сайшаалтай байна. Гэвч хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг үйлдсэн этгээд үйлдсэн гэмт хэргийг хүлээн зөвшөөрч, оногдуулсан ялыг уучлах хүсэлт гаргасан ялтанд уучлал үзүүлэх эрх зүйн боломж нь Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүгийн хуулийн 6.14 дүгээр зүйлд зааснаар нээлттэй байгааг анхаарах шаардлагатай байна.
- ✓ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтран баталсан Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журамд зааснаар хууль сахиулах байгууллагын ажилтан, алба хаагч хохирогчийг таньж тогтоох ажиллагааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/57 дугаар тушаалаар батлагдсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх заавар, асуулга”-ын дагуу явуулах эрх зүйн орчныг энэхүү журмаар тогтоож өгсөн нь сайшаалтай байна.
- ✓ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг даган гарсан журам болон шинээр батлуулсан журмын хэрэгжилтийг хангах, хэрэгжилтийг үр дагаварыг үнэлэх ажлыг зохион байгуулах. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргах Эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ хийх журам, Сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ хийх журам батлуулах ажлыг эрчимжүүлэх хэрэгцээтэй байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ



**ХҮН ХУДАЛДААЛАХ
ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ
БАЙДАЛ**



ХОЁРДУГААР БҮЛЭГ.

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1. ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд ахиц гаргах, шийдвэрлэлтийг дээшлүүлэх хүрээнд Улсын ерөнхий прокурорын 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/73 дугаар тушаал гарч Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйл “Бэлгийн мөлжлөг”, 13.1 дүгээр зүйл “Хүн худалдаалах”, 15.3 дугаар зүйл “Хүний цус, эд эрхтнийг хууль бусаар авах”, 15.4 дүгээр зүйл. Хүний цус, эд, эрхтнийг шаардлага хангаагүй нөхцөлд бэлтгэх, шилжүүлэн суулгах, 15.6 дугаар зүйл. “Бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин, дархлал хомсдолын вирус халдаах”, 12.6 дугаар зүйлд Биеэ үнэлэхийг зохион байгуулах, 13.13 дугаар зүйлд Албадан хөдөлмөрлүүлэх, 16.6 дугаар зүйлд Хүүхэд худалдах, 16.8 дугаар зүйлд Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, 16.9 дугаар зүйлд Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах” гэмт хэргийг Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Хүн худалдаалахтай тэмцэх тасагт харьяалуулсан нь энэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлтэд ахиц гаргах нэг алхам болжээ.

Энэ шийдвэртэй холбоотойгоор Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүрээнд Хүн худалдаалахтай тэмцэх тасгийн чадавхын үнэлгээг хийлгэж, холбогдох байгууллагад танилцуулаад байна.

Хүн худалдаалахтай тэмцэх нөхцөл байдлын үнэлгээний тайланг бэлтгэх зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, түүнд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг 2024 оны байдлаар мөрдөн шалгах ажиллагаа явуулсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйл “Бэлгийн мөлжлөг”, 13.1 дүгээр зүйл “Хүн худалдаалах”, 13.13 дугаар зүйл “Албадан хөдөлмөрлүүлэх” гэмт хэргүүдийг хамруулан улсын хэмжээнд судаллаа.

1.1. МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХЭРГИЙН ТАЛААР

Судалгаанд хамрагдах хугацаанд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйл “Бэлгийн мөлжлөг”, 13.1 дүгээр зүйл “Хүн худалдаалах”, 13.13 дугаар зүйл “Албадан хөдөлмөрлүүлэх” нийт 56 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас 27 буюу 48.2 хувь нь тухайн онд шинээр бүртгэгдэн шалгагдсан хэргүүд байна.



Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан 54 хэргийн 5 буюу 9.3 хувийг хааж, 11 буюу 20 хувийг яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж, хяналт тавьсан хэргийн 16 буюу 29.6 хувийг эцэслэн шийдвэрлэсэн бол 2 хэргийг өөр хэрэгт нэгтгэн, 1 хэргийн мөрдөн байцаалтыг түдгэлзүүлж, оны эцэст 35 хэрэг буюу 64.8 хувь нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд шалгагдаж байна.

Зураг 2. Хэргийн шийдвэрлэлт /зүйлчлэлээр/



Эх сурвалж: УЕПГ-ын тайлан


Судалгаанд хамрагдсан 54 хэргийн 17 буюу 31.5 хувь нь "Бэлгийн мөлжлөг", 32 буюу 59.3 хувь нь "Хүн худалдаалах", 5 буюу 9.2 хувь нь "Албадан хөдөлмөрлүүлэх" гэмт хэрэг байна. Үүнээс 2024 онд шинээр бүртгэгдэн шалгагдсан 27 хэргийн 10 нь бэлгийн мөлжлөгийн, 14 нь хүн худалдаалах, 3 нь албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг байна.

Зураг 3. Шалгагдаж буй нийт хэргийн зүйлчлэл



Эх сурвалж: УЕПГ-ын тайлан

Зураг 4. 2024 онд бүртгэгдсэн гэмт хэргийн зүйлчлэл



Эх сурвалж: УЕПГ-ын тайлан

Шинээр бүртгэгдэн шалгагдсан 27 хэргийн цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байдлыг авч үзвэл, 4 буюу 14.8 хувь нь хохирогч өөрөө хандсан, 16 буюу 59.3 хувь нь тэдний эцэг, эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдээс гомдол, мэдээлэл гаргасан, 7 буюу 25.9 хувийг цагдаагийн байгууллага илрүүлэн шалгасан байна.

Зураг 5. Гомдол, мэдээллийг бүртгэсэн байдал

2024 онд энэ төрлийн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авсан байдал



Эх сурвалж: УЕПГ-ын тайлан

Шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн хавтаст хэргийн материалууд дахь нотлох баримтаас үзвэл энэ төрлийн гэмт хэргийн улмаас хохирч байгаа иргэд өөрсдөө цагдаагийн байгууллагад хандах явдал бага байгаа нь тэдний гэмт этгээдийн худал амлалтад автсан, эрхшээл, дарамтад орсон, мөн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах чадвар сул, эрх зүйн мэдлэг дутмаг байдалтай холбоотой байна гэж үзсэн.

1.2. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ОРОН НУТАГ, АРГА ХЭЛБЭР

Шинээр бүртгэгдэн шалгагдсан 27 хэргийн 1 буюу 3.7 хувь нь орон нутаг буюу Өмнөговь аймагт үйлдэгдсэн бол 26 буюу 96.3 хувь нь нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдэгджээ.

“Орон нутагт насанд хүрээгүй хохирогчийг автомашин ашиглан зөөвөрлөж, бусдад зуучлан, хөдөө хээр талд автомашинд болон айлын орон байр, зочид буудалд олон удаагийн үйлдлээр биеийг нь үнэлүүлж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болгосон тохиолдол бүртгэгдсэн.”


Харин 1 хэрэг Монгол Улсын нилээр нэвтрүүлж үйлдэгдсэн хэрэг байна. Тухайлбал, Яллагдагч Б.Б, Э.Н нар нь гэмт хэрэг үйлдэхээр урьдчилан үгсэн тохиролцож, бүлэглэн 2023 оны 4 дүгээр сарын 21, 26-ны өдрүүдэд нэр бүхий 7 иргэнийг биеийг нь үнэлүүлэх зорилгоор “Тайланд Улсад өндөр цалинтай стриптиз бүжгийн ажил байна, өдөрт 2-3 сая төгрөгийн цалинтай”, “Тайланд Улсад хаусанд байрлаж бусадтай бэлгийн харилцаанд орж 1 удаа 800 юань, хоногийн 5000-6000 юанийн үнэ ханштай цалинтай, бүх зүйл бэлэн санаа зоволтгүй” гэж хууран мэхэлж, эмзэг



байдлыг нь далимдуулж, Тайланд Улс руу онгоцны билет худалдан авч өгч явуулан, бусдад худалдан дамжуулж, хоёр, түүнээс олон хүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлж худалдаалсан гэмт хэргийг үйлдэж, шүүхээр шийтгүүлсэн байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн хэргүүд цахим орчин ашиглаж зар байршуулах, бусдад зуучлах хэлбэрээр үйлдэгдсэнээс гадна 19 буюу 70.4 хувь нь зочид буудалд, 3 буюу 11.1 хувь нь түрээсийн орон сууц, тусгайлан бэлтгэсэн орон байр, ажлын байранд, 5 буюу 18.5 хувь нь өөрийн эсхүл үйлчлүүлэгчийн гэр, автомашинд гэх мэтчилэн бусад газарт биеийг нь үнэлүүлэх хэлбэрээр үйлдэгдэж, 2 буюу 7.4 хувь нь 1-2 удаагийн үйлдлээр, 92.5 хувь нь хэдэн сараар үргэлжилсэн үйлдэлтэй байна.

Зураг 6. Нийслэлийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэргийн байршил



Эх сурвалж: УЕПГ-ын тайлан

“Хүн худалдаалахтай тэмцэх нөхцөл байдал (2022-2023)” тайланд энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж буй гэмт этгээд хохирогчийг айлган сүрдүүлэх, дарамтлах, худал амлалт өгч хуурч мэхлэх зэргээр эрхшээлдээ оруулах, хохирогчийн гар утас, бусад харилцаа холбооны хэрэгсэл, цахим хэрэглээг нь хянах, өөрийн хамаарал бүхий орон байранд байрлуулах, тээврийн хэрэгслээр зөөвөрлөх зэргээр зорчих эрхийг нь хязгаарлаж хяналтдаа байлгах арга хэлбэрээр үйлдэж байсан талаар дурдсан.

Тайлант хугацаад бүртгэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдлаас харвал 2024 онд үйлдэгдсэн гэмт хэргүүд мөн дээрх арга хэлбэрээр үйлдэгдэж байгаагаас гадна цахим орчин, цахим хэрэгсэл ашиглан зар түгээх, бусадтай холбогдох, зуучлах, хохирогчид хяналт тавьж, эрхшээлдээ оруулах арга хэлбэрээр үйлдэгджээ.


Шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн хэргийн материалд дүн шинжилгээ хийж үзвэл гэмт этгээд ашиг олох зорилгоор хохирогч нарын насанд хүрээгүй байдал, тогтмол орлогогүй, мөнгө олох зорилго дээр тулгуурлаж, орон байр, зочид буудлаар хангах, тэдгээрт илүү орлоготой ажиллахын тулд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орох ажлыг санал болгох, үйлчлүүлэгч олж өгөх, насанд хүрээгүй хохирогч нарыг авто тээврийн хэрэгслээр тээвэрлэн, зааварчилга өгөх байдлаар олсон орлогыг нь хураан авах, бусдад биеийг нь үнэлүүлж худалдаалах арга хэлбэрээр үйлдсэн байна.

1.3.ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ЯЛЛАГДАГЧИЙН ХУВИЙН БАЙДАЛ

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нийт 54 хэрэгт 27 хүн яллагдагчаар татагдан шалгагдсанаас 2024 онд шинээр 11 хүнийг яллагдагчаар татаж шалгасан байна. Үүнээс 4 буюу 33.3 хувийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйл “Бэлгийн мөлжлөг”, 7 буюу 58.3 хувийг 13.1 дүгээр зүйл “Хүн худалдаалах” гэмт хэрэгт тус тус яллагдагчаар татан шалгажээ.

2023 онд 16 хүнийг хүн худалдаалах гэмт хэрэгт, 5 хүнийг бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт, нийт 21 хүнийг яллагдагчаар татан шалгаж байсан бол 2024 онд 7 хүнийг хүн худалдаалах гэмт хэрэгт, 4 хүнийг бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт, нийт 11 хүнийг яллагдагчаар татсан нь өмнөх онтой харьцуулахад хүн худалдаалах гэмт хэрэгт яллагдагчаар татсан хүний тоо 9 буюу 56,3 хувиар, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт яллагдагчаар татсан хүний тоо 1 буюу 20 хувиар, нийт яллагдагчаар татсан хүний тоо 10 буюу 47.6 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь анхаарал татаж байна.

Зураг 7. 2024 онд шинээр яллагдагчаар татсан хүний тоо



Эх сурвалж: УЕПГ-ын тайлан

2024 онд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татагдан шалгагдсан 11 хүний 1 буюу 9,0 хувь нь эрэгтэй, 10 буюу 91 хувь нь эмэгтэй, 5 буюу 45,4 хувь нь 17-30 насны, 6 буюу 54,3 хувь нь 31-44 насны, 7 буюу 63,6 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 2 буюу 18,1 хувь нь урьд нь ял шийтгэл эдэлж байжээ.

Яллагдагч нар нь хохирогч нартай ах дүү хамаатан садан, найз нөхөд гэхээсээ илүүтэйгээр хохирогч нарын эмзэг байдлыг нь далимдуулан танилцаж, улмаар харилцаа тогтоон, гэмт хэргийн хохирогч болгосон тохиолдлууд байна.

Зураг 8. Яллагдагчаар татагдсан хүмүүсийн насны байдал



Эх сурвалж: УЕПГ-ын тайлан



Зураг 9. Яллагдагчаар татагдсан хүмүүсийн хүйсийн байдал



Эх сурвалж: УЕПГ-ын тайлан

Зураг 10. Яллагдагчаар татагдсан хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн байдал



Эх сурвалж: УЕПГ-ын тайлан

Зураг 11. Яллагдагчаар татагдсан хүмүүсийн ял шийтгэгдсэн байдал



Эх сурвалж: УЕПГ-ын тайлан

“ Яллагдагчаар татагдан шалгагдаж байгаа хүмүүсийн дийлэнх нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 17-30 насны, эмэгтэйчүүд байгаа нь анхаарал татаж байна. ”

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 7 хэргийн 17 шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ял оногдуулсан байх бөгөөд шүүхээс ял шийтгүүлсэн 17 шүүгдэгчийн 9 буюу 52.9 хувь нь эмэгтэй, 8 буюу 47.1 хувь нь эрэгтэй байна. Насны хувьд 8 буюу 47.1 хувь нь 19-27 насны, 7 буюу 41.2 хувь нь 32-38 насны, 2 буюу 11.7 хувь нь 40-42 насны хүмүүс байжээ. Тэдгээрийн 1 нь дээд, 3 нь бүрэн бус дунд боловсролтой бол 13 нь бүрэн дунд боловсролтой байна.


1.4. ХОХИРОГЧИЙН ХУВИЙН БАЙДАЛ, ГЭМТ ХЭРЭГТ ӨРТӨЖ БУЙ ШАЛТГААН НӨХЦӨЛ

Судалгаанд хамрагдах хугацаанд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан 54 хэрэгт нийт 84 хүн хохирогчоор тогтоогдсоноос тухайн онд шинээр 15 хэрэгт 33 хүн хохирогчоор тогтоогдсон нь өмнөх онтой харьцуулбал 7 буюу 26,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин хүн худалдаалах гэмт хэрэгт 2023 онд 20 хүнийг хохирогчоор тогтоож байсан бол 2024 онд 33 болж 13 буюу 65,0 хувиар өссөн байна.

2024 онд шинээр хохирогчоор тогтоогдсон 33 хүний 8 буюу 24,2 хувь нь бэлгийн мөлжлөг, 17 буюу 51,5 хувь нь хүн худалдаалах, 8 буюу 24,2 хувь нь албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэгт хохирогчоор тогтоогджээ.

“ Гэмт хэргийн улмаас хохирч хохирогчоор тогтоогдсон 33 хүний 7 нь албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэгт хохирогчоор тогтоогдсон гадаад улсын иргэд байна. ”

Зураг 12. 2024 онд хохирогчоор тогтоогдсон хүний тоо /хэргийн зүйлчлэлээр/



Эх сурвалж: УЕПГ-ын тайлан



**“ Цагдаагийн байгууллагаас Гадаад харилцааны
яам, Тагнуулын байгууллагатай хамтран 14 жилийн өмнө
БНХАУ-д худалдаалагдаж, хүн худалдаалах гэмт хэргийн
хохилогч болсон 1 иргэнийг эх оронд нь
эргүүлэн авчирлаа ”**

Гэхдээ уг хэрэгт БНХАУ-ын хууль сахиулах байгууллага мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

2024 онд хохирогчоор тогтоогдсон хүний 10 буюу 30,3 хувь нь насанд хүрээгүй, 32 буюу 96,9 хувь нь эмэгтэй, 1 буюу 3,1 хувь нь эрэгтэй хүн байна.

Хүснэгт 1. Хохирогчдын хувийн байдал

	Үзүүлэлт	Тоо	Эзлэх хувь
Нас	14-17 хүртэлх	10	30.3%
	18-30 хүртэлх	17	51.5%
	31-ээс дээш	6	18.2%
Хүйс	Эрэгтэй	1	3%
	Эмэгтэй	32	96.9%
 Хохирсон гэмт хэрэг	ЭХТА-ийн 12.3 дугаар зүйл “Бэлгийн мөлжлөг”	8	24.2%
	ЭХТА-ийн 13.1 дүгээр зүйл “Хүн худалдаалах”	17	51.6%
	ЭХТА-ийн 13.13 дугаар зүйл “Албадан хөдөлмөрлүүлэх”	8	24.2%

Эх сурвалж: УЕПГ-ын тайлан

Энэ төрлийн гэмт хэрэг хохирогчийг хуурч мэхлэх, дарамтлах байдлаар эрхшээлдээ оруулж, зорчих эрхийг нь хязгаарлаж, хохирогч нарын насны байдал, тодорхой эрхэлсэн ажилгүй, тогтмол орлогогүй байдлыг ашиглан ашиг олох зорилгоор бусдад зуучилж, биеийг нь үнэлүүлэх арга хэлбэрээр үйлдэгдсэн байна.

1.5. ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ХОХИРОГЧИЙН ЭРХИЙГ ХАНГАСАН БАЙДАЛ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.5 дугаар зүйлд зааснаар арван найман насанд хүрээгүй хохирогчид түүний төрсөн, үрчилж авсан эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг, хэрэв дээрх хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр тогтоохоор заасан.

Насанд хүрээгүй хохирогч сэтгэл зүйн хувьд тогтворгүй, айж эмээсэн, гэмт хэргийн улмаас хохирсноо хүлээн зөвшөөрөх, өөрийгөө илэрхийлэх чадамжгүй, өөрийн төрсөн эцэг эх, асран хамгаалагчийн дэргэд нөхцөл байдлыг айдасгүй, илэн далангүй илэрхийлэх боломжгүй байдгаас нөхцөл байдлыг үнэн зөв мэдүүлэхгүй, хэргийн үйл баримтыг үнэн бодитой тогтоох боломжгүй байдлыг үүсгэдэг.

Судалгаанд хамрагдах хугацаанд шинээр хохирогчоор тогтоогдсон 33 хүний 10 буюу 30.3 нь насанд хүрээгүй хүүхдүүд байгаагийн 2 буюу 20 хувьд эцэг эх, асран хамгаалагчийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоон хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулсан бол 8 буюу 80 хувьд нь харьяа нутаг дэвсгэрийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын мэргэжилтнийг хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр тогтоон оролцуулжээ.

Мөрдөгч, прокурор мөрдөн шалгах ажиллагааны явцад, хохирогчийн 80 хувьд мэргэжилтнийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулсан байна.

Энэ нь насанд хүрээгүй хохирогчийн эрхийг хамгаалах, сэтгэл зүйд учирсан гэмтлийг дахин сэдрээхгүй байх, хэргийн бодит байдлыг тогтооход ач холбогдолтой юм.

Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/60, А/40 дүгээр хамтарсан тушаалаар “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам”-ыг баталж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулсан.

Журмын 3.2-т “Насанд хүрсэн хүн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон тухайгаа өөрийн гэр бүлийн бусад гишүүнд мэдэгдэхгүй байх хүсэлтийг эрх бүхий байгууллагад гаргаж болно. Хүсэлтийг хүлээн авсан, шүүгч, прокурор, мөрдөгч хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.” гэж заасан.

Судалгаанд хамрагдсан 54 хэрэгт 84 хүн хохирогчоор тогтоогдсоны 50 нь насанд хүрсэн хохирогч байх боловч мөрдөн шалгах ажиллагааны явцад дээрх хохирогч нараас мөрдөгч, прокурорт хандаж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон тухайгаа өөрийн гэр бүлийн бусад гишүүнд мэдэгдэхгүй байх хүсэлт гаргасан тохиолдол гараагүй, энэ талаарх баримт хэрэгт авагдаагүй байна.

Мөн журмын 3.4-т “Шүүх хуралдаанд биечлэн оролцож, мэдүүлэг өгөх боломжгүй хохирогчийг мөрдөгчийн санал, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн прокурор нь: шүүх хуралдаанаас өмнө дуу, дүрсний бичлэг ашиглан хохирогчоос мэдүүлэг авахыг мөрдөгчид даалгах;” гэж заасан.




Судалгаанд хамрагдсан хэргүүдэд хохирогчийг шүүх хуралдаанд биечлэн оролцож, мэдүүлэг өгөх боломжгүй талаар мөрдөгч, өмгөөлөгчөөс хүсэлт гаргасан талаарх баримт авагдаагүй байна.

Судалгааны явцад хянасан 54 хэргээс 17 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан мөрдөгчийг “хэргийн харьяалал өөрчлөгдсөн”, “ажлын ачаалал тэнцвэржүүлэх”, “ээлжийн амралт авсан”, “албан тушаал өөрчлөгдсөн” гэсэн зайлшгүй шаардлагаар сольсон байх ба тогтоол үйлдэж, хяналт тавьж буй прокурорт тухай бүр мэдэгдэж ажиллажээ.

Хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийн улмаас хохирч, тухайн онд хохирогчоор тогтоогдсон 33 хохирогчийн 12 буюу 36.4 хувь нь өмгөөлөгчгүй мөрдөн шалгах ажиллагаанд оролцсон, 21 буюу 63.6 хувь нь өмгөөлөгчтэй оролцсоноос 14 буюу 66.7 хувь нь улсын өмгөөлөгчөөр хангагдсан байна.

Зураг 13. Өмгөөлүүлэх эрхийн хэрэгжилт



Эх сурвалж: УЕПГ-ын тайлан

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 6.1.1 дэх заалтад “...Эрүүгийн хуулийн Арван зургаадугаар бүлэг (Хүүхдийн эсрэг гэмт хэрэг)-т заасан гэмт хэргийн арван найман насанд хүрээгүй хохирогч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан”, мөн зүйлийн 6.1.2 дахь заалтад “Эрүүгийн хуулийн ...13.1 дүгээр зүйл (Хүн худалдаалах)-д заасан гэмт хэргийн хохирогч төлбөрийн чадваргүй, эсхүл хохирогч нь арван найман насанд хүрээгүй бол түүний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан” тохиолдолд хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэхээр тодорхойлсон.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/399 дугаар тушаалаар батлагдсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”-аар хүн худалдаалах гэмт хэргийн улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан ба журмын 6 дугаар зүйлийн 6.1-д “Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 6.1.2-т заасан хохирогч хүүхдэд хүүхдийн асуудлаар мэргэшсэн, дагнасан улсын өмгөөлөгчөөр үзүүлэх боломжоор хангах” асуудлыг тусгасан.

Тухайн онд хохирогчоор тогтоогдсон 33 хохирогчийн 21 буюу 63.6 хувь нь мөрдөн шалгах ажиллагаанд өмгөөлөгчтэй оролцсоноос 14 буюу 66.7 хувь нь улсын өмгөөлөгчөөр хангагдсан байгаагаас үзэхэд журмын хэрэгжилт тодорхой түвшинд хэрэгжиж байна гэж дүгнэсэн.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хууль зүйн туслалцааны тухай хууль болон “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”-ын хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх байдлыг нэмэгдүүлэх, ялангуяа 18 насанд хүрээгүй бол хүүхдийн асуудлаар мэргэшсэн, дагнасан улсын өмгөөлөгч оролцуулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллахад анхаарах хэрэгтэй.

Шүүх шинжилгээний тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт сэтгэцийн шинжилгээнд тавигдах тусгай шаардлагыг тодорхойлсон, мөн зүйлийн 8 дахь хэсэгт “сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох үнэлгээ”-г тогтоох зорилгоор сэтгэцийн шинжилгээг хийлгэх, 40 дүгээр зүйлд Арван гуравдугаар бүлэг (Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг), ...Арван зургаадугаар бүлэг (Хүүхдийн эсрэг)-т заасан гэмт хэргийн улмаас хохирсон хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргахаар заасан.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан 54 хэргийн 84 хохирогчийн 28 буюу 33.3 хувьд нь тухайн онд шинээр сэтгэцэд учирсан гэмтлийг тогтоолгохоор шинжээч томилж дүгнэлт гаргуулснаас 10 буюу 35.7 хувьд нь “Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээ” хийлгэж, 2 хохирогчид “хор уршиг хоёрдугаар зэрэглэл”-д, 8 хохирогчид “хор уршиг гуравдугаар зэрэглэл”-д байгааг тогтоолгожээ.

Харин 18-д нь “Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээ” хийлгэж, сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоолгоогүй нь тэдний сэтгэцэд ямар нэгэн байдлаар хохирол учраагүй, сэтгэцийн хувьд эрүүл гэсэн шинжээчийн дүгнэлт гарсантай холбоотой байна.

“ 2022, 2023 онд хохирогчдын 25.6 хувь нь сэтгэцэд учирсан гэмтлийн зэрэглэлийг тогтоолгож байсан бол 2024 онд 33.3 хувь болж 7.7 хувиар өсөж эерэг үзүүлэлт гарсан байна. ”

Цаашид хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг шинжилгээ хийлгэж, тогтоолгох, мөн сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн сэргээх, сэтгэл заслын эмчилгээнд зарцуулах зардлыг тогтоосон нотлох баримтыг мөрдөн шалгах ажиллагааны явцад цуглуулж хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажиллагааг улам сайжруулах шаардлагатай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, хохирогчийн хамаарал бүхий этгээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, энэ хуульд заасны дагуу хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалуулах туслалцаа авах хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргаж болно” гэж заасан.



Хохирогчийн амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн, халдахаар завдсан, бэлтгэсэн, эсхүл халдлага бодитой эхэлсэн тохиолдолд мөрдөн шалгах эрх бүхий байгууллага, албан тушаалтан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авч, шийдвэр гаргуулахаар шүүхэд даруй хандах хуулийн зохицуулалттай.

Судалгаанд хамрагдсан хэргүүдэд, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, хохирогчийн хамаарал бүхий хүн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалуулах туслалцаа авах хүсэлт гаргасан талаарх баримт авагдаагүй байна.

1.6.ХЭРЭГ БҮРТГЭЛТИЙГ ХААЖ ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН ТАЛААР

Судалгаанд хамрагдсан хугацаанд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан 54 хэргээс 5 хэргийг хааж шийдвэрлэснээс 3 хэргийг “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр, 2 хэргийг “хөөн хэлэлцэх хугацаа дууссан” үндэслэлээр хааж шийдвэрлэжээ. Хэрэг бүртгэлтийг хааж шийдвэрлэсэн хэрэг урьд оноос 7 хэргээр буюу 58 хувиар буурсан байна.

Зураг 14. Хааж шийдвэрлэсэн хэргийг зүйлчлэл, үндэслэлээр харуулбал,



Эх сурвалж: УЕПГ-ын тайлан

Хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн үндэслэлийг авч үзвэл, иргэд, төрийн байгууллагаас хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл ирүүлснийг цагдаагийн байгууллага хүлээн авч, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйл “Бэлгийн мөлжлөг”, 13.1 дүгээр зүйл “Хүн худалдаалах”, 13.13 дугаар зүйл “Албадан хөдөлмөрлүүлэх” гэмт хэргээр тус тус зүйлчлэн хэрэг бүртгэлтийн хэрэг нээн, мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад мөрдөгчөөс хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтуудаар:

- Хүн худалдаалах гэмт хэргийн шинж болох худалдаалах зорилгоор хохирогчийн зорчих эрхийг нь хязгаарлаж, өөрсдийн болон бусдын эрхшээлд бүрэн оруулах, элсүүлэх, тээвэрлэх, орогнуулах, дамжуулах, хүлээн авах байдлаар бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулсан, боолчилсон, хөдөлмөрийн мөлжлөгт оруулсан гэх,
- Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шинж болох хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, аливаа хэлбэрээр эрхшээлдээ оруулах, түүнчлэн эрхшээлдээ байгаа байдлыг нь далимдуулан бэлгийн харьцаанд албадан оруулсан,
- Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн шинж болох хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн гэх үйл баримт тогтоогдоогүй бөгөөд тухайн гэмт хэргийн шинжгүй нөхцөл байдал тогтоогдож, прокурор мөрдөгчөөс гаргасан саналыг үндэслэн хэрэг бүртгэлтийг хааж шийдвэрлэжээ.

1.7. ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭГДСЭН ХЭРГИЙН ТАЛААР

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан 54 хэргээс 26 хүнд холбогдох 11 хэрэгт яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлснээс 18 хүнд холбогдох 7 хэргийг шүүх хянан хэлэлцэж шийдвэрлэсэн, 8 хүнд холбогдох 4 хэрэг хянан хэлэлцэгдээгүй байна.

Прокуророос Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3, 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг журамлан мөн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.2 дахь хэсэгт зааснаар мөрдөн шалгах ажиллагаа явуулж, шүүхэд шилжүүлсэн 6 шүүгдэгчтэй 1 хэргээс 1 шүүгдэгчид холбогдох хэргийг “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, цагаатгасан ба 1 хэргийн зүйлчлэлийг өөрчилж Эрүүгийн хуулийн 12.5 дугаар зүйлд заасан “Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох” гэмт хэргээр шийдвэрлэжээ.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 7 хэргийн 17 шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 16 шүүгдэгчид 1 жилээс 12 жилийн хугацаагаар хорих ял, 1 шүүгдэгчийн зүйлчлэлийг өөрчлөн, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Арван найман насанд хүрсэн хүн хохирогчийг арван дөрвөн насанд хүрсэн, арван зургаан насанд хүрээгүй болохыг мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 5,000 нэгж буюу 5,000,000 төгрөгийн торгох ял оногдуулсан байна.

Ял шийтгэгдсэн 17 шүүгдэгчийн 1 буюу 5,8 хувь нь БНХАУ-ын иргэн бол бусад 16 шүүгдэгч Монгол Улсын иргэд байна.

Шүүхээс торгох ял оногдуулсан 1 шүүгдэгч нь БНХАУ-ын иргэн бол Монгол Улсын иргэд бүгд хорих ялаар шийтгүүлсэн, хорих ял шийтгэгдсэн 1 шүүгдэгчийг хорих ялыг хаалттай дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэжээ.



Хүснэгт 2. Шүүхээс гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ял оногдуулсан байдал

№	Шүүгдэгчийн тоо	Гэм буруутайд тооцсон хуулийн зүйл, хэсэг	Оногдуулсан ялын төрөл, хэмжээ	Хорих байгууллагын төрөл
1	МУ-ын иргэн-2	13.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.1 дэх заалт "Хүн худалдаалах гэмт хэргийг байнга тогтвортой үйлдсэн"	12 жил хорих	Нээлттэй
2	МУ-ын иргэн-2	13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.2 дахь заалт "Хүн худалдаалах гэмт хэргийг "хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж", "хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж үйлдсэн"	6 жил хорих	Нээлттэй
3	МУ-ын иргэн-1	13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.2 дахь заалт "Хүн худалдаалах гэмт хэргийг "хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж", "хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж үйлдсэн"	9 жил 7 сар, 29 хоног хорих	Хаалттай
4	МУ-ын иргэн-4	13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.2 дахь заалт "Хүн худалдаалах гэмт хэргийг "хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж", "хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж үйлдсэн"	5 жил хорих	Нээлттэй
5	МУ-ын иргэн-1	12.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дахь заалт "Хүн худалдаалах гэмт хэргийг "хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж"	1 жил хорих	Нээлттэй
6	МУ-ын иргэн-2	13.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг "Биеийг нь үнэлүүлэх хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулах зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эмзэг байдлыг нь далимдуулж худалдсан"	1 жил 1 сар хорих	Нээлттэй
7	МУ-ын иргэн-1	13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.2, 2.3 дахь заалт "Хүн худалдаалах гэмт хэргийг "хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж", "Монгол улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн"	3 жил, 6 сар хорих	Нээлттэй
8	МУ-ын иргэн-1	13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.2, 2.3 дахь заалт "Хүн худалдаалах гэмт хэргийг "хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж", "Монгол улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн"	5 жил хорих	Нээлттэй
9	МУ-ын иргэн-2	13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалт "Хүн худалдаалах гэмт хэргийг "хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж"	6 жил хорих	Нээлттэй
10	БНХАУ-ын иргэн-1	12.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг "Арван найман насанд хүрсэн хүн хохирогчийг арван дөрвөн насанд хүрсэн, арван зургаан насанд хүрээгүй болохыг мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон ² "	5,000,000 төгрөгийн торгох	-

Эх сурвалж: УЕПГ-ын тайлан

² Шүүхээс зүйлчлэл өөрчлөн шийдвэрлэсэн

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хэргийн оролцогчийн гомдлоор 4 хэргийг хянаж, 2 хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээн, оролцогчийн гомдлыг хэрэгсэхгүй болгож, 2 хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн 3 заалтад өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн. Тухайлбал,

- 1 хэргийн шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 5 дахь заалтыг “Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт зааснаар гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан тээврийн хэрэгслийн үнэ 8,424,000 төгрөгийг хувь тэнцүүлэн шүүгдэгч нараас тус бүр 4,212,000 төгрөгийг, шүүгдэгч Б.Д-ын гэмт хэрэг үйлдэж олсон орлого 1,760,000 төгрөг, шүүгдэгч Б.Н-ын гэмт хэрэг үйлдэж олсон орлого 12,850,000 төгрөгийг ...” гэж өөрчилж, тогтоох хэсгийн бусад заалтуудыг хэвээр үлдээж, гомдлыг хэрэгсэхгүй болгож,
- 1 хэргийн шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 2 болон 3 дахь заалтын “6 жилийн хугацаагаар” гэснийг “...5 жилийн хугацаагаар” гэж тус тус өөрчилж, бусад заалтыг хэвээр үлдээн, шүүгдэгч, тэдгээрийн өмгөөлөгч нараас гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгож. Шүүгдэгч нар нь насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгч Т.А-ын хууль ёсны төлөөлөгч О.Т-д 8,000,000 төгрөгийг төлсөн талаар дурдаж тус тус өөрчлөлт оруулан шийдвэрлэсэн байна.

Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хэрэг хянан хэлэлцсэн тохиолдол гараагүй байна.

Шүүхээс гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдож ял шийтгүүлсэн 17 шүүгдэгчийн 5 нь урьд 3-9 удаагийн “Залилах”, “Хулгайлах”, “Дээрэмдэх”, “Хүчиндэх”, “Танхайрах”, “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах” гэмт хэрэг үйлдэж, ял эдэлж байжээ.

Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдсон 17 шүүгдэгчийн 1 хэргийн 1 шүүгдэгч дангаараа гэмт хэрэг үйлдсэн бол 1 хэргийн 3 шүүгдэгч, 1 хэргийн 5 шүүгдэгч, 4 хэргийн тус бүр 2 шүүгдэгч бүлэглэн гэмт хэрэг үйлдсэн байна.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.7 дугаар зүйлд “Гэмт хэргийг хоёр, түүнээс олон хүн санаатай нэгдэж үйлдсэн бол бүлэглэн гүйцэтгэх” гэж, 3.8 дугаар зүйлд “Гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн гурав, түүнээс олон хүний тогтвортой нэгдлийг зохион байгуулалттай гэмт бүлэг” гэж тус тус тодорхойлсон.

Шүүхээр гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдож ял шийтгүүлсэн 16 шүүгдэгч нь 2-5 уулаа бүлэглэн, санаатай нэгдэж гэмт хэрэг үйлдсэн байх бөгөөд тэднийг зохион байгуулалттай гэмт бүлэг гэж үзэх үндэслэл тогтоогдоогүй байна.

Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн 7 хэргээс:

- 1 хэрэгт гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар огт дурдаагүй
- 1 хэрэгт насанд хүрээгүй хохирогчид гэмт хэргийн улмаас учирсан хохирол болох 3,500,000 төгрөгийн хохирол төлөгдсөн талаар,
- 4 хэрэгт хохирогч нар нь цаашид гарах эмчилгээний зардал, сэтгэцэд учирсан хор уршгийг нотлох баримтаа бүрдүүлж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар жич нэхэмжлэх эрхтэй талаар,



- 2 шүүгдэгчтэй 1 хэрэгт 1 шүүгдэгч нь гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, хор уршиг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд 9,150,000 төгрөгийг төлсөн, бусдад төлөх төлбөргүй талаар дурдаж, 1 шүүгдэгчээс гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн зардалд 7,160,100 төгрөг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд 2,750,000 төгрөг, нийт 9,910,100 төгрөгийг гаргуулж, “Хүйсийн тэгш эрхийн төв” төрийн бус байгууллагын дансанд төлүүлэхээр шийдвэрлэсэн.

Мөн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан:

- 1 хэргийн 2 шүүгдэгчээс гэмт хэрэг үйлдэж олсон орлого болох 3,705,000 төгрөгийг хувь тэнцүүлэн 1 шүүгдэгчээс 1,852,000 төгрөгийг,
- 1 хэргийн 5 шүүгдэгчээс гэмт хэрэг үйлдэж олсон орлого болох 3,484,000 төгрөгийг хувь тэнцүүлэн 1 шүүгдэгчээс 696,800 төгрөгийг,
- 1 хэргийн 2 шүүгдэгчээс гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан тээврийн хэрэгслийн үнэ болох 8,424,000 төгрөгийг хувь тэнцүүлэн 1 шүүгдэгчээс 4,212,000 төгрөгийг,
- 1 шүүгдэгчээс гэмт хэрэг үйлдэж олсон орлого болох 1,760,000 төгрөгийг,
- 1 шүүгдэгчээс гэмт хэрэг үйлдэж олсон орлого болох 12,850,000 төгрөгийг,
- 1 хэргийн 2 шүүгдэгчээс гэмт хэрэг үйлдэж олсон орлого болох 8,775,000 төгрөгийг хувь тэнцүүлэн 1 шүүгдэгчээс 4,387,500 төгрөгийг тус тус гаргуулж, улсын төсөвт шилжүүлэхээр,
- 1 хэргийн 3 шүүгдэгчээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.4 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 161 дүгээр тогтоолын 2.6.6-д заасныг баримтлан хууль зүйн үйлчилгээний зардал 2,000,000 төгрөгийг хувь тэнцүүлэн гаргуулж, насанд хүрээгүй хохирогчийн өмгөөлөгчид олгохоор тус тус шийдвэрлэсэн байна.

2.ХОХИРОГЧ ХАМГААЛАЛ

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хохирогчид туслалцаа дэмжлэг үзүүлэх зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/40 тушаалаар “Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх”, Гадаад харилцааны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/71 тушаалаар “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх” журмыг тус тус шинэчлэн баталж, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 215 дугаар тогтоолоор “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах” журмыг шинээр баталжээ.

2024 онд үйлчилгээ үзүүлэгч төрийн болон төрийн бус байгууллага нийт 37 хохирогч/үйлчлүүлэгчийг таньж тогтоож, илрүүлсэн нь өмнөх жилээс 30,8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллагын хувьд санхүүжилт тогтмол бус байсан нь энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг таньж тогтоох, илрүүлэлт буурахад нөлөөлсөн байх магадлалтай байна.

Зураг 15. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандсан хохирогч/үйлчлүүлэгчдийн тоон мэдээлэл /жилээр/



Эх сурвалж: ХГБХХЕГ, Хүйсийн тэгш эрх төв, Талита ази ТББ-ын тайлан

Энэхүү тайланд ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс, Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газарт хандсан хохирогч/үйлчлүүлэгчдийн тоон мэдээллийг тусгахын зорьсон. Үүнээс Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар 2024 онд бэлгийн мөлжлөгт өртсөн 10 насанд хүрээгүй хүнийг таньж тогтоож, илрүүлсэн³. Харин ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь 2024 онд хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн гэрч, хохирогчид хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүлээн аваагүй ба хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлээгүй байна⁴ гэжээ.

³ Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын мэдээлэл

⁴ ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс, 2025 оны 07 дугаар сарын 07-ны 11е/10188 тоот Албан бичиг



Зураг 16. Хохирогч/үйлчлүүлэгчдийн тоо, байгууллагаар



Эх сурвалж: ХГБХХЕГ, Хүйсийн тэгш эрх төв, Талита ази ТББ-ын тайлан

Өмнөх жилтэй харьцуулахад үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагад хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн хохирогчид хандах, мөн хохирогчдыг таньж тогтоох, илрүүлэх, хүлээн авч эхэлсэн нь хохирогч хамгааллын үйлчилгээнд ахиц гарч буй харуулж байна. Мөн түүнчлэн Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэст ялангуяа хуулийн байгууллагад хандаж хохирогчоор тогтоогдсон хүнийг хандуулах, тэднийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан 4 төрлийн туслалцаанд (хууль зүйн туслалцаа, сэтгэл зүйн туслалцаа, эрүүл мэндийн туслалцаа, нийгмийн туслалцаа) хамруулах чиглэлээр үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд хамтран ажиллах боломж нээлттэй байна.

Төрийн бус байгууллагад хандсан 37 хохирогч/үйлчлүүлэгчид нь хүйсийн хувьд бүгд эмэгтэй бөгөөд 20 буюу 54,05 хувь нь насанд хүрээгүй хүн, 17 буюу 45,94 хувь нь насанд хүрсэн хүн байна.

Зураг 17. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн байдал



Эх сурвалж: ХГБХХЕГ, Хүйсийн тэгш эрх төв, Талита ази ТББ-ын тайлан

“ Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт өртөж буй насанд хүрээгүй хүний тоо буурахгүй байна. ”

Насанд хүрээгүй хүн энэ төрлийн гэмт хэрэгт өртөх тохиолдол буурахгүй байгаа ба харин өртсөн хохирогч/үйлчлүүлэгчид нь үйлчилгээ үзүүлэгч болон хууль сахиулах байгууллагад хандаж, туслалцаа, дэмжлэгт хамрагдаж байгаа нь чухал үр дүн юм.


Үйлчилгээ авсан 37 хүнээс насанд хүрээгүй хүнтэй холбоотой бүхий л тохиолдлыг цагдаагийн байгууллагад хандуулсан бол насанд хүрсэн хүний хувьд дийлэнх нь цагдаагийн байгууллагад хандсан гэх мэдээлэл байна. Харин өмнөх бүлэгт дурдсанчлан 2024 онд цагдаагийн байгууллагад хохирогчоор 33 хүнийг тогтоогдсон бөгөөд энэ үзүүлэлтээс харахад үйлчилгээ үзүүлэгчээс хохирогч/үйлчлүүлэгчдийн дийлэнх олонхыг хуулийн байгууллагад хандуулж байгааг нөхцөл ажиглагдав.

Түүнчлэн үйлчилгээ үзүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагад хандсан хүнийг хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэгт өртсөн байршлаас нь харахад бүгд дотооддоо өртөж хохирсон байна. Мөн энэ төрлийн гэмт хэрэгт гадаад улсын иргэд, ЛГБТ, хөгжлийн бэрхшээлтэй хүн өртсөн гэх тохиолдол бүртгэгдээгүй байна.

“ Үйлчилгээ авсан хохирогчид нь дунджаар 88 хоног буюу 2 сар гаруй хугацаанд түр хамгаалах байранд байрлаж байна. Нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх тохиолдолд хохирогч/үйлчлүүлэгчдийг урт хугацаанд түр хамгаалан байрлуулах байр хэрэгцээ, шаардлагатай байна. ”

Хүйсийн тэгш эрх төв ТББ 1 үйлчлүүлэгчийг дунджаар 88 хоног, Талита ази ТББ 1 үйлчлүүлэгчийг дунджаар 90 хоног байрлуулжээ. Харин төрийн байгууллагын хувьд хамгаалах байрны үйлчилгээг 3 хохирогч/үйлчлүүлэгчдэд үзүүлсэн гэх бөгөөд хэд хоног байрлуулсан талаарх мэдээлэлгүй байна.

Зураг 18. Хамгаалах байраар үйлчлүүлсэн хохирогч/үйлчлүүлэгч, байгууллагаар



 Байрласан хоног

 Хохирогчийн тоо

Эх сурвалж: ХГБХХЕГ, Хүйсийн тэгш эрх төв, Талита ази ТББ-ын тайлан



Хамгаалах байранд байрлах хугацаанд хохирогч/үйлчлүүлэгчдэд нийгмийн ажлын кейс менежментийн үе шатаар үйлчилгээ үзүүлдэг ч тэрхүү үйлчилгээ нь анхан шатны шууд туслалцаа, дэмжлэг байсан бөгөөд тэдгээрт урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлээгүй байна.

Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүрээнд гэр бүл, хүүхэд, хөдөлмөр хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэд зөвхөн бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхдийг Түр хамгаалан байрлуулах байрыг байгуулсан. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын мэдээллээс харахад Хүүхдийн тусламжийн утас 108 дугаараас 2024 онд холбон зуучлах үйлчилгээний хүрээнд хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн долоон /7/ насанд хүрээгүй хүнийг хамгаалах байранд байрлуулахаар ирүүлсэн байна. Энэ нь хохирогч/үйлчлүүлэгчийн кейс дээр хамтран ажиллах, тэднийг дахин хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, үйлчилгээг хүртээмжтэй, тасралтгүйгээр үзүүлэх хамтын ажиллагааны эхлэл тавигдаж байгааг харуулж байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12-р сард “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах” шинэ журмыг баталсан ба тус журмыг зорилтод бүлгийн мэргэжилтэн, албан хаагчдад танилцуулах, мэдээлэл өгөх сургалт, уулзалтыг зохион байгуулах шаардлагатай нь зэрэгцээ хэрэгжилтийг ханган ажиллах нь чухал юм. Журам хэрэгжсэнээр түр хамгаалах байрны төсөв, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, үйлчилгээ үзүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагууд нэгдсэн стандартаар үйлчилгээг үзүүлэх боломжууд нээгдэж байгаа билээ.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хувьд анхан шатны туслалцаа дэмжлэгийг хохирогч/үйлчлүүлэгч бүрд үзүүлдэг ба урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлээгүй байна. Зураг 19-т тусгагдсан нөхөн сэргээх үйлчилгээнд сэтгэл засал, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, өмгөөллийн туслалцаа зэрэг үйлчилгээ багтсан.

Зураг 19. Хохирогч/үйлчлүүлэгчдэд үзүүлсэн үйлчилгээний төрөл, байгууллагаар



Эх сурвалж: ХГБХХЕГ, Хүйсийн тэгш эрх төв, Талита ази ТББ-ын тайлан

Үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллагуудын хувьд 2024 онд хууль зүйн туслалцааны нэг төрөл болох өмгөөллийн үйлчилгээнд нийт 10 хохирогчийг хамруулсан. Өмгөөллийн үйлчилгээг үзүүлэхдээ гэрээт өмгөөлөгчидтэй хамтран ажилласан ба үйлчилгээний төлбөр нь өмнөх жилийн төлбөртэй харьцуулахад өөрчлөлт гаргаагүй байна.

Мөн холбон зуучлах үйлчилгээнд нийт 17 хохирогч/үйлчлүүлэгчийг хамруулж, үйлчилгээг тасралтгүй, үргэлжлүүлэн үзүүлжээ. Энэ нь хохирогч төвтэй хандлагыг төлөвшүүлж байгаагийн зэрэгцээ хохирогч/үйлчлүүлэгчийг дахин хохирогч болохоос хамгаалах, үйлчилгээг мэргэшсэн багаар үзүүлэх, нэн шаардлагатай үйлчилгээг хамтран үзүүлэх гэх зэрэг олон давуу талтай юм.

Дээрх үйлчилгээг үзүүлэхэд үйлчилгээнд зориулсан санхүүжилт, төсөв хамгийн чухал юм. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд Хүн худалдаалахтай тэмцэх, ялангуяа хохирогч хамгааллын үйл ажиллагаанд жил бүр 30,000,000 /гучин сая/ төгрөгийн санхүүжилттэй зөвлөх ажил, үйлчилгээг сонгон шалгаруулах журмаар үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлсээр иржээ.

Дээрх санхүүжилтийг зардлаар нь ангилахад 18,750,000 төгрөг буюу 62.5 хувь нь хохирогч/үйлчлүүлэгчдэд анхан шатны туслалцаа үзүүлэх, 6,975,000 төгрөг буюу 23.25 хувь нь хүний нөөцийн зардал, 4,275,000 төгрөг буюу 14.25 хувь нь хамгаалах байрны урсгал зардал эзэлж байна.

Зураг 20. Хамгаалах байрны зардлын тооцоо



Эх сурвалж: Хүйсийн тэгш зрх төв ТББ-ын тайлан



Харин Талита Ази төрийн бус байгууллагын хувьд тухайн жилд нийт хохирогч хамгааллын зардал нь 11,720,251.00 төгрөг байсан ба энэ нь зөвхөн үйлчилгээний зардал бөгөөд хүний нөөц, урсгал зардал ороогүй байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын хувьд 2024 оны байдлаар хүүхэд хамгааллын зардлаас нийт 1,377,133,000 төгрөгийн санхүүжилтийг 21 аймаг, 9 дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, хэлтсийн харьяа 17 түр хамгаалах байр, 9 нэг цэгийн үйлчилгээний төвд олгосон байна⁵.

Үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллагуудаас үйлчилгээтэй холбоотой зардал буюу хувьсах зардлын дэлгэрэнгүй тооцооллыг гаргаж өгөхийг хүссэн ч мэдээлэл ирүүлээгүй байна.

Харин үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллага болох Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс хохирогчид үйлчилгээ үзүүлэх, хяналтын хэрэгт зарцуулах зардлын тооцоолол, жишиг норматив тогтоох боломжгүй⁶ гэсэн хариуг өгсөн байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын хувьд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 52 дугаар зүйлийн хүүхэд хамгааллын санхүүжилт, төлөвлөлттэй холбоотой заалтыг үндэслэн 2024 онд Засгийн газраас 236 дугаар тогтоолоор “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал”, “Хүүхэд хамгааллын үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын норматив”-ыг баталсан ба энэ хүрээнд үйлчилгээтэй холбоотой зардлыг улсын төсвөөс гаргадаг гэв.

Дээрх зардал нь хохирогч хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд хангалтгүйгээс гадна гүйцэтгэлээр тайлагнаж үйлчилгээнд зарцуулсан зардлыг нөхөн авдаг нь хүндрэл учруулдаг талаар үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөл илэрхийлж байсан.

Учир нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд ихэвчлэн ашгийн бус, ямар нэгэн орлого олох үйл ажиллагаа эрхэлдэггүй ба санхүүжилтийн эх үүсвэргүй тогтмол бус байдаг. Үүнээс улбаалан хохирогч/үйлчлүүлэгчдэд үзүүлэх үйлчилгээ хүртээмжгүй, тогтмол биш байх нь хохирогч төвтэй хандлагыг бэхжүүлэхэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй юм.

⁵ Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын мэдээлэл

⁶ ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс, 2025 оны 07 дугаар сарын 07-ны 11е/10188 тоот Албан бичиг

3.УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөл Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд ажиллана” гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 21 тогтоолоор Засгийн газрын Үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсантай холбоотойгоор Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталжээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд ажиллаж буй Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл 2024 онд 3 удаа хуралдаж, дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 5 зорилт, 28 ажил төлөвлөснөөс жилийн гүйцэтгэлийн биелэлт 88.2 хувьтай байжээ.

Дэд зөвлөл нь Хүн худалдаалахтай тэмцэх хуульд заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр зохицуулжээ. Үүнд:

- хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тайлан мэдээллийг сонсох, шалгалт явуулах, зөвлөмж гаргах;
- хүн худалдаалах нөхцөл байдлын талаар мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагаар судалгаа хийлгэх, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөр уламжлан Засгийн газарт оруулах;
- хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр бусад орны холбогдох байгууллагатай хамтран ажиллах чиглэл гаргаж хэрэгжүүлэх;
- хүн худалдаалахтай тэмцэхэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах, хамтран ажиллах, санал санаачилгыг нь дэмжих, олон нийтэд чиглэсэн урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;
- хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомж зөрчсөн, гэмт хэрэг гарах шалтгаан, нөхцөлийг бүрдүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд зохих хариуцлага хүлээлгэх саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд гаргах, биелэлтийг шаардах;
- иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтныг урамшуулах арга хэмжээ авах;
- хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгуулах талаар санал боловсруулах;
- хүн худалдаалах, түүний хор уршгийн талаарх нэгдсэн мэдээг гаргах;



- хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээний стандартын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;
- хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагын ажилтныг мэргэшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах зэрэг байна.

3.1. ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ САНХҮҮЖИЛТ

Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардалд 244,9 сая төгрөгийг тусгасан нь өмнөх онтой харьцуулбал 3,3 сая төгрөг буюу 1,3 хувиар өссөн байна. Тухайн төсвийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулан зарцуулж байна.

Тухайлбал, шүүх шинжилгээний байгууллагад шаардлагатай Полимеразын гинжин урвалын аппарат болон ДНХ ялгах төхөөрөмж, цагдаагийн байгууллагын энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авахын зэрэгцээ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, тогтоомжийг сурталчлах, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын түр хамгаалах байрны үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих чиглэлээр зөвлөх үйлчилгээнд зарцуулжээ.

3.2. ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН СУДАЛГААНЫ ТОЙМ

Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 2024 онд 4 судалгааны ажил хийгдсэн нь 2023 оноос өссөн үзүүлэлт байна.

Хийгдсэн судалгааны ажлуудын үр дүнг авч үзвэл:




“Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогоор гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлж буй практик” сэдэвт судалгааны ажил

Энэхүү судалгааг Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч насанд хүрээгүй хүнд учирсан хохирлыг барагдуулах, нөхөн олговор олгох хууль эрх зүйн үндэслэл, тогтолцооны загварыг судлан тодорхойлж, дутагдалтай талыг сайжруулах, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийн хохирлыг нөхөн төлөхөд ашиглах зорилгоор практикийн бодлогын судалгааг хийж гүйцэтгэжээ.

Судалгаанаас хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хохирол, хор уршгийг шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхийн шийдвэрийг илүү төгөлдөржүүлэх зорилгоор дараах зөвлөмжийг өгчээ. Үүнд:

- Хохирогчид учирсан гэм хорын хохирлыг тогтоох зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу хүн худалдаах гэмт хэргээс шууд шалтгаантайгаар эрүүл мэнд нь өвчилсөн, эмгэгтэй болсон, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байдал нь муудсан байдлыг тогтоох ажиллагааг мөрдөн шалгах ажиллагаанд хийх, үүнтэй холбоотой Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах;
- Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирогч эмэгтэйн төрүүлсэн хүүхдэд хэрэг үйлдсэн этгээдээс сар бүр хүүхдийн тэтгэлэгтэй тэнцэх хэмжээний нөхөн төлбөрийг гаргуулахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Хохирогч эдгэршгүй өвчин, эмгэгтэй болсон бол энэ талаар тусгай мэдлэг бүхий шинжээчийн дүгнэлтийг гаргуулж, гэм хорын хохирлын нэхэмжлэх бүх ажиллагааг мөрдөгч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нар хийх;
- Шүүхээс Эрүүгийн хуулийн “эрүүгийн хариуцлага нь тухайн хүний үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.” гэсэн шударга ёсны зарчимд, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “...хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино” гэсэн зорилгод нь нийцүүлэн хохирогчийн хохирол, хор уршгийн талаар нэхэмжлэлээ иргэний журмаар жич нэхэмжлэх эрхтэй гэж шийдвэрлэж байгаа тохиолдолд “шүүгдэгчийг бусдад төлөх төлбөргүй” гэж шийтгэх тогтоолдоо дүгнэнхгүй байх;
- Хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлдэг мэргэшсэн өмгөөлөгч нарыг бэлтгэх;
- Хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогддог Гэр бүл, хүүхэд хөгжлийн газрын мэргэжилтнүүдийн хохирогчид үзүүлэх дэмжлэг, туслалцаа, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох мэдлэгийг сайжруулж, чадавхжуулах;
- Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг хаашаа хэрхэн орж байсан зарцуулагдаж байсан зэргийг тогтох ажиллагааг хийж, гэмт хэрэг үйлдэж олсон орлого, хөрөнгийг бүрэн хураахуйц ажиллагааг мөрдөн байцаалтад бүрэн хийх;
- Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 1,3 дахь хэсэгт зааснаар хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэж байх зэргийг дурджээ.



Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, насанд хүрээгүй хохирогчид нөхөн төлбөр олгох талаар олон улсын сайн туршлагыг судалж, өөрийн улсад хэрэгжүүлэх зохистой арга, хэлбэрийг тодорхойлох, санал зөвлөмж боловсруулах бодлогын судалгаа

Энэхүү судалгааг Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид, ялангуяа насанд хүрээгүй хохирогчдод нөхөн олговор олгох асуудлыг олон улсын сайн туршлагын хүрээнд судалж, манай улсад хэрэгжүүлэх боломжтой зохистой арга хэлбэрийг тодорхойлох зорилгоор хийж гүйцэтгэжээ. Судалгааг хийж гүйцэтгэхдээ АНУ, Франц, Нидерланд, ХБНГУ, Япон, Тайвань, Молдав, Румын, Тайланд зэрэг 9 орны сайн туршлагыг сонгон судалж, дараах зөвлөмжийг өгчээ.

Үүнд:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу хохирогч иргэний нэхэмжлэл гаргахад хохирогч, хохирогчийн өмгөөлөгчөөс гадна прокурорын нотлох баримт бүрдүүлэх чиг үүргийг хуульчлах;
- Мөн хуулийн дагуу хохирогч нөхөн олговор авах эрхийн талаар мөрдөгч, прокурор, шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат болгонд мэдээлэл хүргэх үүргийг хуульчлах;
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хохирлыг нөхөн төлүүлэхэд гэмт хэрэгтний хөрөнгийг мөшгөх, царцаах, хураан авах талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар мөрдөгч, прокурорт үүрэг болгосон заалтыг хуульчлах;
- Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн талаар хуульчлахдаа санг бүрдүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө, хандив тусламж, шүүхээс оногдуулсан торгох ялын 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө, гэм буруутай этгээдээс хохирол барагдуулсан төлбөр байна гэжээ. Иймд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10.2.3-т эд хөрөнгө хураах ялын хөрөнгийг нэмж оруулах;
- Тус хуулийн 10.3 дугаар зүйлд хохирогчид нөхөн төлбөр олгох төрлийг эмчилгээний зардал, оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс түүнтэй адилтгах орлого гэж хязгаарласан нь учир дутагдалтай байна. Олон улсын эх сурвалж, гадаадын туршлагыг харгалзан, хуурч мэхлэн, хууль бусаар суутгаж байсан төлбөр буюу байрны түрээс, тээвэр, амьжиргааны зардал, татвар зэргээр гэмт этгээдээс “зохиомол өр” үүсгэж байсан суутгалыг нөхөн олговорт хамааруулах нь зүйтэй. Үүнийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10.3.4. Бусад зардал гэж нээлттэйгээр нэмэх;

- Хохирогчийг бусдын зүгээс буруутгаж харьцах нь хохирол нөхөн төлүүлэхэд саад учруулж байна. Иймд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой харьцахдаа хохирогч төвтэй хандлагад суурилах, хохирогчийг өөрөө буруутай тул гэмт хэргийн хохирогч болсон гэж үзэх байдлыг өөрчлөх нь зүйтэй. Иймд ЭХХША-ны явцад мөрдөгч, прокурор, шүүгч хохирогчийг буруутгасан хандлага гаргахгүй байх, хохирогчийн эрхийг хамгаалах, хохирогч төвтэй хандлагыг төлөвшүүлэх талаар сургалтыг явуулах;
- Олон улсад хохирогчийн нөхөн олговор авах талаар тулгамдаж буй асуудлыг эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт, хууль сахиулах байгууллага, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын үүрэг, төрийн механизмтай холбоотой гэж үзэхийн зэрэгцээ хохирогчийн зарим үйл ажиллагаа нь хохирлоо нөхөн төлүүлэхэд саад болж байгаа талаар дурдсан байна. Иймд хохирогчид сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх явцад хохирлоо төлүүлэх талаар зөвлөх нь зүйтэй байна.
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15.1-т хохирогчийн нэхэмжилж болох нөхөн төлбөрийн хэлбэрийг эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирлоор хязгаарласан нь учир дутагдалтай байна. Иймд тус заалтад бусад хохирлын төрлийг тодорхой тусгахаар нэмэлт өөрчлөлт оруулах;
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хохирол нөхөн төлүүлэх нь эрх зүйн зохицуулалтын хувьд бүрхэгдүүлж байгаа тул Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд 15.4 дэх хэсэгт хохирогч хохирлоо нөхөн төлүүлэх талаар тусгайлсан журам батлах тухай заалт нэмэх нь зүйтэй зэргийг дурджээ.



Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээ: харьцуулсан судалгаа

Энэхүү судалгааг Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүрээнд хүн худалдаалах гэмт хэргийн ухагдахууныг олон улсын эрх зүйн баримт бичигт тусгасан агуулгыг тодруулах, мөн манай улсад хуульчилж ирсэн уламжлал, шүүхээр шийдвэрлэж буй практикийг судлахаас гадна гадаадын зарим улс орны эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалж уг гэмт хэргийг хуульчлах, өрсөлдөх хэм хэмжээнээс ялган зүйлчлэх, ялын бодлогын хүрээнд санал дэвшүүлжээ.

Судалгааг гүйцэтгэхдээ Англи-Америкийн бүл, Эх газрын бүл, холимог бүлийг төлөөлүүлэн Бүгд Найрамдах Солонгос Улс, Тайвань Улс, Холбооны Бүгд


Найрамдах Герман Улс, Америкийн Нэгдсэн Улс, Канад Улсыг сонгон судлав. Эдгээр улсыг сонгохдоо хүн худалдаалах гэмт хэргийн тайлангийн шатлалыг харгалзан үзжээ. Судалгаанаас дараах зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

- Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Албадан бэлгийн харьцаанд оруулах” хэмээн томъёолж өөр зүйлд хуульчлах, 12.3 дугаар зүйлийн 2 дахь



хэсгийг буюу бэлгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийг 13.1 дүгээр зүйлийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчлах;

- Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хүндрүүлэх шинжид оногдуулах эрүүгийн хариуцлагыг хүн худалдаалах гэмт хэргээс хүнд ял оногдуулахаар хуульчлах;
- Дээрх гэмт хэргүүдийг хохирогчийн эрүүл мэндэд хохирол учруулж үйлдсэн, амь насыг нь хохироосныг хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчлах;
- Улсын дээд шүүхээс хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарах бусад гэмт хэргийг ялган зүйлчлэх талаарх албан ёсны тайлбар гаргах зэргийг дурджээ.



Монгол Улсын хууль сахиулах байгууллага хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд нээлттэй эх сурвалжийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх (OSINT) аргачлалыг ашиглах боломжийг тодорхойлоход чиглэсэн судалгаа

НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас хэрэгжүүлсэн “Цахимаар үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, хянан шалгах ур чадварыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд хийж гүйцэтгэжээ.

Судалгаа нь Монгол Улсын Засгийн Газар, тэр дундаа хууль сахиулах байгууллагад OSINT шинжилгээг ашиглахтай холбоотой аливаа сургалтыг тогтвортой зохион байгуулахад чиглэсэн бодлого, стандартыг боловсруулах, OSINT шинжилгээг хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгахад ёс зүйтэй ашиглах,

мэдээллийн алдагдал, халдлагаас түргэн шуурхай хамгаалах, ил тод байдлаар хариу арга хэмжээ авах, хохирогчийн сэтгэцийн эрүүл мэндийг нэн тэргүүнд тавьж, хохирогчийн сэтгэцийн гэмтлийн нөхцөл байдалд суурилсан арга барилыг ашиглан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглүүлэх, дэмжлэг үзүүлэхэд чиглэгджээ.

Судалгааны үр дүнгээр дараах зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

- Монгол Улсын цагдаагийн байгууллага хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах хүрээнд OSINT шинжилгээг тогтмол хийж эхлэхээс өмнө нээлттэй эх сурвалжийн мэдээллийг цуглуулах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, ашиглах үйл ажиллагааг зохицуулах журмын төслийг боловсруулахыг зөвлөж байна.
- Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасгийг санхүүгийн нөөц боломжоор хангах боломжтой бол OSINT шинжилгээг тогтмол хийх тусгайлсан шинжээч буюу мэргэжлийн шинжээчийг томилон ажиллуулахыг зөвлөж байна. Мөн шинжээчийг урт хугацааны ажлын баталгаатай байртай байлгахын тулд шаардлагатай төсвийг шийдвэрлэхийг зөвлөж байна.

- Мэргэжилтнүүдийг шинжээч эсвэл судлаачдад зориулсан OSINT шинжилгээний сургалтад хамруулах, цахим орчинд мэдээлэл цуглуулах, бэхжүүлэх, үнэлэх, шалгах ажиллагааны талаар мөрдөгч нарт гүнзгийрүүлсэн сургалт зохион байгуулах, прокурор, шүүхийн ажилтнуудыг мэдээлэл технологийн чиглэлээр сургах, энэ чиглэлээр мэргэшсэн үндэсний сургагч багш бэлтгэх шаардлагатай байна.
- Хууль сахиулах байгууллага, олон улсын байгууллага, төрийн үйлчилгээ үзүүлэгч, төрийн бус байгууллага гээд хүн худалдаалах гэмт хэрэгт хохирогчдын эрх, ашиг, хэрэгцээг нэн тэргүүнд тавьж, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтран ажиллах, олон талт хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэсэн тогтсон загварыг нэвтрүүлэн хэрэгжүүлэх хэрэгтэй байна.
- OSINT-ийн шинжилгээг хийхээс өмнө алба хаагчдад ажлын шаардлагаар үзэж, унших, судлах шаардлагатай болох контентын агуулга, тухайн контентоос болж ажил, гэр бүлийн амьдралд гарч болох сэтгэл зүйн нөлөөллийн талаар бүрэн мэдээлэл өгөхийг зөвлөж байна. Мөн алба хаагчид байнга сэтгэл зүйн туслалцаа авах боломж нөхцөлийг бүрдүүлэхийг зөвлөж байна. Алба хаагчид сэтгэлзүйн дэмжлэг, туслалцаа заавал авах шаардлагагүй байсан ч сэтгэл зүйн хувьд эрүүл байлгах зорилгоор зарим төрлийн үзлэг, оношилгооны арга хэмжээг авч хэрэгжүүлж байх шаардлагатай юм.
- Хуульд тусгагдаагүй байсан ч цагдаагийн байгууллага хувь хүний мэдээлэл алдагдах асуудлыг шийдэх протоколыг бий болгох шаардлагатай. Хувийн мэдээлэл алдагдсан талаар эрх бүхий байгууллага буюу Хүний эрхийн үндэсний комисс болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хэрхэн мэдэгдэх, хамтран ажиллах талаарх зохицуулалт шаардлагатай байна.
- Хууль сахиулах байгууллагууд хил дамнан гарч буй цахим орчныг ашиглан үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдээллийг олж мэдсэн тохиолдолд шуурхай хариу арга хэмжээ авч ажиллахын тулд, бусад оронтой хамтын ажиллагааны механизмтай байх шаардлагатай төдийгүй хэрвээ тогтсон механизм одоогоор байхгүй байгаа бол энэ талаар санаачилгатай ажиллах шаардлагатай юм.
- Хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллахаар зөвшөөрч хэргийн талаар мэдээлэл өгөх хохирогчдод учирч болох сэтгэл зүйн хохирлыг багасгахын тулд гэмт хэргийг шийдвэрлэхэд оролцож буй бүхий л талуудад хохирогч төвтэй, гэмтлийн дараах мэдээлэлд суурилсан арга барилыг эзэмшүүлэх талаар сургалт явуулах, хохирогч төвтэй тогтолцоог бий болгох шаардлагатай зэргийг дурджээ.

“ Ийнхүү хийгдсэн судалгааны үр дүнг олон нийтэд тархааж, цахим хэлбэрээр ашиглах боломжтой байдлаар байршуулж буй боловч бодлогын баримт бичиг боловсруулах, үйл ажиллагааны төлөвлөлтөд ашиглах явдал хангалтгүй байна. ”




3.3. ХҮҮХДИЙГ МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХЭД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/49 дүгээр тушаалаар батлагдсан “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг Хил хамгаалах байгууллага, Цагдаагийн байгууллага ханган ажиллаж байна.

2024 онд улсын хилээр нийт 603,624 (гарсан 309,180 орсон 294,444) хүүхдийг шалган нэвтрүүлсэн бөгөөд хилээр гарсан хүүхдийн 1,963 нь эцэг эх, асран хамгаалагчийн итгэмжлэлтэй, 9,509 нь цагдаагийн байгууллагын зөвшөөрөлтэй (олон улсын уралдаан тэмцээнд 8454, урлаг соёлын арга хэмжээнд 480, сурагч, оюутан солилцоогоор 575) байна.

Улсын хилээр нэвтэрсэн боловч хилийн чанадад үлдсэн 2,231 хүүхдийн буцаж ирээгүй шалтгааныг тогтоон ажиллажээ.

Зураг 21. Улсын хилээр гарах чиглэлд нэвтэрсэн хүүхдийн тоо



Эх сурвалж: ХХЕГ-ын тайлан

“Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх журмыг шинэчлэн боловсруулж, шаардлагатай зөвшөөрлийн механизмыг цахимжуулах шаардлагатай байна.”

Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журмын хэрэгжилтийг хангах, хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тогтоох, шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор оролцогч талуудын уулзалт хэлэлцүүлгийг 3 удаа зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлгээс гарсан санал зөвлөмж, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газарт хүргүүлсэн байна.


3.4. ХИЛ ДЭЭРХ ДАМЖИН ӨНГӨРҮҮЛЭХ АЖИГЛАЛТЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах төслийн хүрээнд Анбаунд Монгол төрийн бус байгууллагаас Чингис хаан, Замын-Үүд, Алтанбулаг боомтын хил дээрх дамжин өнгөрүүлэх ажиглалтын судалгааг хийж гүйцэтгэж байна.

**“ Хил дээрх дамжин өнгөрүүлэх ажиглалтаар
Чингис хаан боомт дээр 45, Замын-Үүд боомт дээр 47,
Алтанбулаг боомт дээр 2 иргэнийг хүн худалдаалах гэмт
хэрэгт өртөх эрсдэлтэй гэж тогтоожээ. ”**

Чингис хаан боомт дээр тайлант хугацаанд 895 иргэнээс асуулга авснаас 36,7 хувь буюу 329 зорчигч хүүхэд, 43,7 хувь буюу 392 зорчигч нь 18-29 насны, 19.6 хувь буюу 176 зорчигч 30-аас дээш насны хүн байсан. Зорчигчдын 315 буюу 35 хувь нь аялах, 229 буюу 25,5% нь ажиллах, 219 буюу 24,4 хувь нь сурах, 105 нь тэмцээнд оролцох, 9 нь эмчилгээ хийлгэх зорилгоор зорчжээ.

Зураг 22. Чингис хаан боомт дээр асуумж авсан иргэдийн насны байдал



Эх сурвалж: Анбаунд Монгол ТББ-ын тайлан

Нийт асуулга авсан зорчигчдоос эрсдэлд байж болзошгүй гэж үзсэн 45 зорчигчтой тусгайлан ярилцаж мэдээлэл өгсөн бөгөөд эдгээр зорчигчдод ганцаараа эсвэл танихгүй, гадаад хүнтэй хамт зорчиж байгаа, очих газарт нь тосох хүнгүй, аяллын аюулгүй байдалдаа эргэлзсэн, хэн нэгний эрхшээлд орсон зэрэг шинж тэмдгүүд ажиглагдсан гэжээ.

Замын-Үүд боомт дээрх ажиглалтын судалгаанд хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлд байж болзошгүй нийт 6,072 зорчигч хамрагдсан бөгөөд эдгээр зорчигчдын 35.5% нь аялах, 12.6% нь сурах, 2.7% нь ажиллах, 19.5% бараа авах, 30% нь тэмцээнд оролцох зорилгоор зорчсон.

Үүнээс эрсдэлтэй гэж үзсэн 47 зорчигчийг тогтоосон ба тэдгээрээс 37 (18-аас доош насны 25) зорчигч аяллаа зогсоожээ. Аяллаа зогсоосон зорчигчдын шалтгааныг авч үзвэл:



Хүснэгт 3. Аяллаа зогсоосон шалтгаан (давхардсан тоогоор)

Замын-Үүд боомтод зорчигч хүүхдүүд аяллаа зогсоох болсон шалтгаан



Эх сурвалж: Анбаунд Монгол ТББ-ын тайлан

Анбаунд Монгол ТББ-аас эдгээр зорчигчдын аюулгүй байдалд хяналт тавин ар гэртэй нь холбогдон хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн байж болзошгүй зарим тохиолдолд эрсдэлд буй зорчигчийн мэдээллийг цагдаагийн байгууллагаар шалгуулахаар шилжүүлжээ.

Алтанбулаг авто замын боомтод нийт 107 эрсдэлд байж болзошгүй зорчигчдоос асуулга авч хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл өгсөн. Эдгээр зорчигчдын 44.8 хувь буюу 48 нь насанд хүрээгүй зорчигчид байсан.

Алтанбулаг авто замын боомтоор зорчигчдын аяллын чиглэл ОХУ-ын Хиагт, Улаан-Үд хот байсан бөгөөд 39% нь хүнс бараа авах, 25% нь тэмцээнд оролцох, 18% нь аялах зорилгоор, 11% нь ажиллах зорилгоор зорчиж байсан ба зорчигчдын дийлэнх нь Сэлэнгэ аймгийн харьяат иргэд байсан бөгөөд ихэнхдээ хилээр гарсан өдөртөө буцаж орж ирж байлаа.

Алтанбулаг авто замын боомтод хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэл бүхий 2 тохиолдлын 1 эрэгтэй, 1 эмэгтэй (насанд хүрсэн) илрүүлж, урьдчилан сэргийлэх ярилцлага хийснээр аяллаа зогсоосон байна.

Дорнод аймгийн Чойбалсан сумын Хавирга хилийн боомт болон Халхгол сумын Баянхошуу хилийн боомтод богино хугацаанд буюу 2024 оны 6 дугаар сарын 10-16-ний өдрүүдэд ажиглалтыг хийжээ.

Дээрх хугацаанд Зорчигчийн аюулгүй байдлын асуулга, хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлд буй эсэхийг тогтоох маягтын шалгуур үзүүлэлтийн дагуу хилээр нэвтэрч буй хүүхэд, ганцаараа болон группээр зорчиж буй эмэгтэйчүүд, залуу хүмүүсийг түлхүү ажиглалт хийсэн

Нийт 53 зорчигч, түүнээс 29 нь эмэгтэй, 24 нь эрэгтэй зорчигч бөгөөд 37 зорчигч нь Хавирга боомтоос Алтан-Эмээл (27%), Манжуур (66%), Хайлаар чиглэлд зорчжээ. Зорчигчдын 66 хувь нь аялал, 17 хувь нь худалдаа наймаа, үлдсэн нь ажил болон бусад зорилгоор зорчсон.

Харин Баянхошуу боомтод 18 зорчигчоос асуулга авсан бөгөөд 88% нь Амгалан чиглэлд 6 зорчигч эмчилгээ хийлгэх, 5 зорчигч аялах, 5 хүн хүнс худалдан авахаар зорчиж байсан бол хил рүү ачаа тээвэрлэж байсан хоёр ажилтан байсан.

Зорчигчдоос асуулга авч хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл бүхий хавчуурга, яаралтай нөхцөлд холбогдох байгууллагуудын мэдээлэл тараасан байна.

3.5. СУРГАЛТ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын нэг чиглэл нь тухайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилладаг төрийн, иргэний нийгмийн байгууллагын албан хаагч, мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулах явдал юм.

Хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх чиг үүргийн байгууллагуудад чиглэсэн сургалтыг 2024 онд түлхүү зохион байгуулагдсан бөгөөд нийт сургалтад 1532 алба хаагч хамрагдсан нь өмнөх оноос өссөн үзүүлэлт байна.

“ Хүн худалдаалах гэмт хэргийн чиглэлээр үндэсний хэмжээнд 38 алба хаагч сургагч багшаар бэлтгэгдсэн байна. ”

Түүнчлэн үндэсний сургагч багш бэлтгэх чиглэлээр Форензик ярилцлага хийх сургагч багш бэлтгэх сургалт, Кибер орчныг ашиглан үйлдсэн хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа сургагч багш бэлтгэх сургалт тус тус зохион байгуулагдаж, 38 албан хаагч үндэсний сургагч багшаар бэлтгэгдсэн байна. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 2024 онд зохион байгуулсан сургалтын талаарх мэдээллийг нэгтгэн авч үзвэл:

- Цахимаар үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх хянан шалгах ур чадварыг бэхжүүлэх нь сэдэвт сургалтад Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Дотоод хэргийн их сургуулийн төлөөлөл нийт 15 алба хаагч,
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийг таньж илрүүлэх, холбогдох үйлчилгээнд хандуулах сэдэвт сургалтад Чингис Хаан олон улсын нисэх буудалд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын 300 алба хаагч,
- Форензик ярилцлага хийх сургагч багш бэлтгэх сургалтад хууль сахиулах, нийгмийн хамгааллын салбарын 25 алба хаагч,
- Хүн худалдаалах гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж үзүүлэх нь сэдэвт сургалтад нийгмийн хамгаалал, хууль сахиулах салбарын 40 алба хаагч,
- Хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт, энэ төрлийн гэмт хэрэгт өртөж хохирсон хүнд тусалцаа үзүүлэх сэдэвт сургалтад Монгол Улсаас хилийн чанадад суугаа ДТГ-уудад шинээр томилогдсон 44 албан хаагч,
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сэдэвт сургалтад Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын 45 алба хаагч,




- Мөрдөн шалгах ажиллагааны хохирогч төвтэй арга барил-хандлага сэдэвт сургалтад Цагдаагийн ерөнхий газар, Шүүх шинжилгээний ерөнхий газрын 63 алба хаагч,
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх нь сэдэвт сургалтад Хууль зүйн туслалцааны төв, Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбооны төв орон нутгийн 105 өмгөөлөгч,
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхэдтэй сэтгэцийн гэмтэлд суурилсан аргачлалаар ажиллах нь сэдэвт сургалтад Цагдаагийн ерөнхий газар, Шүүх шинжилгээний ерөнхий газрын 30 алба хаагч,
- Хүн худалдаалах болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чадавх бэхжүүлэх сэдэвт сургалтад Алтанбулаг, Хавирга, Баянхошуу боомтын хилийн хяналтын байгууллагын 130 алба хаагч,
- Кибер орчныг ашиглан үйлдсэн хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа сургагч багш бэлтгэх сургалтад Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Дотоод хэргийн их сургуулийн 13 алба хаагч,
- Кибер орчныг ашиглан үйлдсэн хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа Төв аймаг, Багануур, Багахангай, Налайх дүүргийн прокурор, цагдаагийн 25 алба хаагч тус тус хамрагджээ.
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын алба хаагч, мэргэжилтнүүдэд зориулсан Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх, тогтоох зааврыг 2022 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан. Хүйсийн тэгш эрх төв ТББ-аас энэхүү зааврыг мэргэжлийн бүлгүүдэд таниулах, алба хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 300 орчим нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хүүхэд хамгааллын ажилтнуудад мэдээлэл өгөх, мэдлэг олгох сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулжээ.
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг дагаж гарсан журмын хэрэгжилтийг хангах, хэрэгжүүлэгчдэд таниулах, тэдний ур чадварыг нэмэгдүүлэх зорилготойгоор сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, нийт 396 алба хаагчдыг (244 эмэгтэй, 152 эрэгтэй) хамруулжээ.

“Хилийн хяналтын байгууллага, нисэх буудлын захиргаа, авиа компанийн албан хаагчдыг сургалтад хамруулсан нь онцлог арга хэмжээ болсон.”

НҮБ-аас жил бүрийн 7 дугаар сарын 30-ны өдрийг “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх Дэлхийн өдөр” болгон зарлаж, “Хөх зүрхний аян”-ийг өрнүүлж эхэлсэн.


2024 онд тус аяныг “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд нэг ч хүүхдийг бүү орхигдуул” уриан дор зохион байгуулж, хүн худалдаалах гэмт хэргийн талаарх олон нийтийн ойлголт, мэдээллийг нэмэгдүүлэх чиглэлээр мэдээлэл өгч ажиллажээ.

Зураг 23. Хөх зүрхний аян



Түүнчлэн хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд Монгол контент ХХК-тай хамтран ажиллах гэрээг байгуулж, цахим орчинд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 7 рийл бичлэг, 4 ярилцлага, 4 видео бичлэг, 1 нийтлэлийг олон нийтэд түгээжээ.

Зураг 24. Зөвлөх үйлчилгээний үеийн мэдээлэл



Б.Ерөөлт: Бид гэрч, хохирогчийг хамгийн уртдаа гурван жил хүртэлх хугацаагаар хамгаалсан

ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Ерөөлтэй ярилцав. Тэрээр хүн худалдаалах гэмт хэргийн

48 5 2024-05-20 17:16



Э.Алтанхуяг: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид цагдаа руу өргөдлөө барьж ирдэггүй

ЭЦА-ны Зохион байгуулалттай гэмт хэргтэй тэмцэх хэлтсийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Э.Алтанхуягтай ярилцав. Тус хэлтэс хүн

77 13 2024-05-18 17:22



Г.Амаржаргал: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид насан туршдаа сэтгэл зүйн гэмтэлтэй үлддэг

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөлийн Ажлын албаны ахлах мэргэжилтэн Г.Амаржаргалтай хүн худалдаалах гэмт хэргийн

197 5 2024-05-04 12:14



Ж.Баасанжав: Хүн худалдаалах гэмт хэргийн хүүхдийн эсрэг үйлдвэл 12 хүртэл жил хорих ялтай


"Их Засаг" олон улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрүүгийн эрх зүйн танхимийн эрхлэгч, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч

359 9 2024-05-03 08:00



Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүрээнд “Мөрөөдлийнхөө зүг” мэдээллийн компанит ажлыг 2024 оны 11 дүгээр сард зохион байгуулсан ба энэ компанит ажил нь хүүхдийн мөрөөдлийг анаж суудаг, хүүхэд залуусын итгэмтгий занд дөрөөлөн гэмт хэрэгтнүүд ямар өгөөш занга хэрэглэдэг, хохирогч хүүхдүүдийг цахим орчинд хэрхэн хуурдаг, энэ төрлийн гэмт хэргээс өөрийгөө, өрөөл бусдыг хэрхэн хамгаалах талаар мэдлэг мэдээлэл олгох зорилготой бөгөөд аяны хүрээнд видео нэвтрүүлэг 2, текст контент 4, видео контент 3, рийл 3, постер 2, комик 1, стикер 1, подкаст 1-ийг бэлтгэн, www.gogo.mn, www.yolo.mn www.cccp.gov.mn, www.famliycenter.mn сайтуудаар түгээлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (хуучин нэрээр), Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Дэлхийн зөн Монгол ОУБ хамтран 2024 оны 6-р сарын 12-нд “Амлалтаа биелүүлье” уриан дор бодлогын зөвлөгөөнийг 100 гаруй оролцогчидтойгоор зохион байгуулжээ.




Зөвлөгөөнөөр холбогдох яам, агентлагууд, төрийн болон төрийн бус байгууллагын мэргэжилтнүүд, багш, судлаачид оролцон хүүхдийн хөдөлмөр, ялангуяа хүүхдийн албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад тулгамдаж буй асуудлуудын талаар хэлэлцсэн. Мөн тус Зөвлөгөөнөөр хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах олон талт арга хэмжээ, хамтын ажиллагаа, сайн жишээнүүд, хэрэгжиж буй бодлого болон 2023 оны бодлогын зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийн хэрэгжилт зэргийг хэлэлцжээ.

Анбаунд Монгол төрийн бус байгууллагаас өсвөр үеийн хүүхэд залууст зориулсан “Ухаалаг хөтөч”-хүн худалдаалах гэмт хэрэг, аюулгүй шилжих хөдөлгөөний талаар болон амьдрах ухааны талаар цогц ойлголт өгөх 31 багц хичээл бүхий хөтөлбөр, “Өөрчлөлтийн төлөөх дуу хоолой”-хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг дуу хоолойгоо нэгтгэн нийгэмдээ өөрчлөлт авчрах нөлөөллийн аян зохион байгуулах аргачлалд сургах 20 багц хичээл бүхий шинэчилсэн хөтөлбөр, “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал”-цахим орчныг зөв зохистой хэрэглэх суурь ойлголт, зан дадалд сургах, цахим орчин дахь болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг нийт ерөнхий боловсролын 70 сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн 100 гаруй төв хэрэгжүүлж байна.

Хүснэгт 4. Тоон мэдээлэл

Хөтөлбөрийн нэр	Клубийн тоо	Чиглүүлэгч багш	Чиглүүлэгч сурагч	Хамрагдсан буй хүүхдийн тоо
Ухаалаг хөтөч хөтөлбөр	40	74	91	1097
Өөрчлөлтийн төлөөх дуу хоолой хөтөлбөр	26	51	36	503
Өөрчлөлтийн төлөөх дуу хоолой холимог хөтөлбөр	19	36	28	328
ЦОХАБ өсвөрийн клуб	16	28	0	360
Нийт	101	189	155	2288

Зураг 25. Чиглүүлэгч багш нарт зориулсан гарын авлага



Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиуд дээрх хөтөлбөрийн чиглүүлэгч багш нарт зориулсан туршлага солилцох уулзалт болон стресс менежмент үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд нийт 49 чиглүүлэгч багш, нийгмийн ажилтан оролцож, туршлага солилцох, стрессийн менежментийн сургалтын үр дүнд сургагч багш нар стрессийг даван туулах арга зүйд суралцжээ.

Зураг 26. Сургагч багш нарын сургалт





4. ХАМТЫН АЖИЛЛАГАА

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэдэх Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл нь улсын хэмжээнд хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг уялдуулах, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэгтэйгээр ажилладаг.

4.1. ОЛОН УЛСЫН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

Монгол Улс хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тэлж, төрийн бусад байгууллага болон олон улсын байгууллагуудтай нягт уялдаатай ажиллажээ.

Зураг 27. Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд

Олон улсын төсөл хөтөлбөр	АНУ-ын Төрийн департаментын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт” төсөл
	Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь цахим хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах ур чадварыг бэхжүүлэх нь” төсөл
	АНУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас хэрэгжүүлж буй Албадан хөдөлмөрөөс сэргийлэх, тэмцэх нь» төсөл

Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төсөл

Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Төрийн департамент хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийг 2020 оноос эхлэх хэрэгжүүлж байна.

Төслийн хэрэгжилтэд Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Улсын ерөнхий прокурорын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанаас хяналт тавьж, ерөнхий удирдлагаар ханган, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулж, төслийг Дэлхийн зөн Монгол, Азийн сан олон улсын байгууллагын хамтарсан консорциум хэрэгжүүлж байна.

Төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг тогтмолжуулан хэрэгжүүлж байна. Тухайлбал,

- ✓ “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах төслийн хэрэгжилтийн явц байдалд дүн шинжилгээ хийх, танилцах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл солилцох хоёр улсын Засгийн газрын дээд хэмжээний уулзалтыг жил бүр зохион байгуулдаг;

- ✓ Салбар дундын хамтарсан багийн үйл ажиллагаа жилээр төлөвлөн хэрэгжүүлж, багийн гишүүдийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр менторшип хөтөлбөрийг хэрэгжүүлдэг;
- ✓ Хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг асуудал, шийдэл хэлэлцүүлгийг жил бүр зохион байгуулдаг;
- ✓ Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаас гадна хил хамгаалах, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, хөдөлмөр, авто болон агаарын тээврийн салбарын албан хаагч, мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх сургалтыг зохион байгуулсан;
- ✓ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох;
- ✓ Урьдчилан сэргийлэх чиглэлээр, сургуульд суурилсан өсвөр үеийнхэнд зориулсан хөтөлбөрүүд, зорилтот хороодод сайн дурын ажилтнуудаар дамжуулан мэдээлэл түгээх, хил дээр дамжин өнгөрөх ажиглалт, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, хамгаалах байрны үйл ажиллагааг бэхжүүлэх, хүүхдийн эрхийн болон хөдөлмөрийн улсын байцаагчдыг чадваржуулах;
- ✓ Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж буй зарим байгууллагын материаллаг баазыг нэмэгдүүлэх
- ✓ Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хамгааллын цогц үйлчилгээг үзүүлэхийн тулд богино болон урт хугацааны хамгаалах байруудад техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг тодорхой, үр дүнтэй ажлууд хийгдсэн байна.

Монгол Улс дахь цахим хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах ур чадварыг бэхжүүлэх нь төсөл

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанаас НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран Бали Процессын Ази Номхон Далайн бүс нутгийг хариуцсан газрын санхүүжилтээр “Цахимаар үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх хянан шалгах ур чадварыг бэхжүүлэх нь” нэг жилийн хугацаатай төслийг ОУШХБ-ын Хөгжлийн сангийн санхүүжилттэйгээр 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хооронд хэрэгжүүлжээ.

Төслийн хүрээнд “Монгол Улсын хууль сахиулах байгууллага хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд нээлттэй эх сурвалжийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх (OSINT) аргачлалыг ашиглах боломжийг тодорхойлоход чиглэсэн судалгаа”-г гүйцэтгэсэн. Судалгааны үр дүн, санал зөвлөмжийг энэ оны 02 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулагдсан Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн хуралд танилцуулсан байна.

Мөн “Нээлттэй эх сурвалжийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх (OSINT) тухай” 3 үе шат бүхий сургалтыг 2024 оны 01 дүгээр сарын 16-18, 04 дүгээр сарын 9-10, 06 дугаар сарын 12-13-нд тус тус зохион байгуулж, сургалтад хууль сахиулах, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн 6 байгууллагын нийт 19 албан хаагч хамрагджээ. Энэхүү сургалтыг Бали Процессын Үндэстэн дамнасан гэмт хэрэг ба технологийн хөтөлбөрийн менежер Раян Винч,



OSINT шинжээч, криминологи, сургагч багш Анн-Лин Дудэнхофер нар удирдан явуулав. Сургалтаар албан хаагчид цахим орчин дахь нээлттэй эх сурвалжийн мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, аюулгүй ажлын байраа бэлтгэх, олон нийтийн сүлжээг хянах, газар зүйн байршил тогтоох, хуурамч мэдээллийг ялгах, цахим ул мөрийг мөрдөх, цахим нотлох баримт цуглуулах зэрэг мэдлэг ур чадварыг эзэмшиж, цахим ул мөрийг гар утасны дугаар болон и-мэйл хаягаар шүүж цуглуулах “Epioes” болон “OSINT Industries” төлбөртэй програмд нэвтэрч, болзошгүй гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаандаа хэрэглэх эрх олгосон байна.

“Албадан хөдөлмөрөөс сэргийлэх, тэмцэх БРИЖ-II» төсөл

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанаас НҮБ-ын олон улсын хөдөлмөрийн байгууллага хамтран 2023 оны 07 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж буй “БРИЖ-2” төслийн хүрээнд хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын албан хаагч, мэргэжилтнүүдэд албадан хөдөлмөрийг таних, илрүүлэх, энэ төрлийн гэмт хэргийг шалгах, шийдвэрлэх чиглэлээр мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх чиглэлээр сургалтын гарын авлага боловсруулах ажлыг эхлүүлжээ.

Энэ хүрээнд ГХУСАЗЗАА-ны даргын 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/11 дугаар тушаалаар техникийн ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд сургалтын модуль боловсруулах олон улсын болон дотоодын зөвлөхүүдийн боловсруулсан модулийн агуулгыг техникийн ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн дэмжжээ.

4.2. ОЛОН УЛСЫН ХУРАЛ, ЗӨВЛӨГӨӨН

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас Тайланд улсын Бангкок хотноо 2024 оны 03 дугаар сарын 18-21-ний өдрүүдэд зохион байгуулсан “Хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөрийн асуудлаарх Ази, Номхон далайн бүсийн уулзалт”-ад Монгол Улсаас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн холбоо, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Хүйсийн тэгш эрх төв төрийн бус байгууллагын төлөөлөл оролцжээ.

Уулзалтаар Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнууд 2019 оноос хойш хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөрийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болон хүрсэн ололт, амжилтын талаар мэдээлэл солилцохын зэрэгцээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Хүүхдийн сан, Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний байгууллагаас хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах, албадан хөдөлмөрийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцсон байна.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас 2024 оны 04 дүгээр сарын 15, 16-ны өдөр Австри улсын Вен хотноо зохион байгуулсан “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эвслийн 24 дэх удаагийн бага хурал”-д салбар дундын хамтарсан багийн гишүүд оролцсон байна.

Бага хуралд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын гишүүн улс орон, олон улсын байгууллагын 270 орчим төлөөлөгч оролцож, 2023-2024 онд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний талаар мэдээлэл солилцож, туршлагаа хуваалцжээ. Тус хурлаар хэлэлцсэн асуудлыг тоймлон авч үзвэл:

1. Улс орнууд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаандаа дахин хяналт-үнэлгээ хийх;
2. Улс орнууд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тасралтгүй, байнгын шинжтэй хийх үүднээс үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх;
3. Улс орнууд хүн худалдаалах гэмт хэрэг нь хар тамхи, цахим залилан, хууль бусаар хил нэвтрэх зэрэг гэмт хэрэгтэй хамт үйлдэгдэж байгаад анхаарч ажиллах;
4. Улс орнууд өөрсдийн оронд ажиллаж, амьдарч байгаа цагаач иргэд, дүрвэгч, гадаад ажиллах хүчний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар тодорхой ажил зохион байгуулах;
5. Хүүхдийг хүн худалдаалах, ялангуяа хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор уул уурхай, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарт ажиллуулж байгааг анхаарч, хүүхэд хамгааллын чиглэлээр тодорхой, үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах;
6. Улс орнууд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаандаа зарцуулах төсвийг нэмэгдүүлж, энэ нь хохирогчийг илрүүлэх, тэдэнд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ажилд илүү их хөрөнгө оруулалт хийх;
7. ЕАБХАБ-ын дэргэд Хүн худалдаалах гэмт хэргийн даван туулагчдын олон улсын эвсэл байгуулагдсантай холбоотойгоор улс орнууд дотооддоо хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч-даван туулагчдын төрийн бус байгууллагатай байгуулах боломжийг судлах;
8. Улс орнууд хүн худалдаалах гэмт хэргийн талаарх статистикийн мэдээллийг дан ганц гэмт хэргийн статистикаас гадна хохирогч хамгааллын чиглэлээр дата цуглуулахад анхаарч, оролцогч байгууллагуудыг хамарсан нэгдсэн платформтой болохыг зорих;
9. Улс орнууд хүүхдээр гуйлга гуйлгах, хүүхдийг гэмт хэрэгт уруу татах нь хүн худалдаалах гэмт хэрэгт хүүхдийг өртүүлж буй хэлбэр тул энэ төрлийн гэмт үйлдлийг хүн худалдаалах гэмт хэрэгт тооцоход анхаарах;
10. Улс үндэстний доторх үндэсний цөөнх иргэдийн хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлийг бууруулахад чиглэсэн ажил зохион байгуулах;
11. Улс орнууд хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнууд, мэргэжилтнүүд болон өмгөөлөл, нийгмийн халамжийн үйлчилгээний ажилтнуудын хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдлэг ойлголтыг тасралтгүй дээшлүүлэх;
12. Улс орнууд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг цахим сүлжээ ашиглан зохион байгуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байдлыг харгалзан үзэх;



13. Улс орнууд хүүхдийн эсрэг үйлдэж байгаа цахим хүчирхийлэл, мөлжлөгтэй тэмцэхэд анхаарч ажиллах;
14. Улс орнууд аж ахуйн нэгж байгууллагын удирдах албан тушаалтнуудыг хүн худалдаалах, албадан хөдөлмөрийн талаарх сургалтад хамруулж, дотоодын болон гадаадын ажилтан, цагаач, дүрвэгсдийг хөдөлмөрийн мөлжлөгийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх зэрэг асуудлыг хөндсөн байна.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Нарийн бичгийн дарга нарын дэргэдэх Үндэстэн дамнасан аюул заналтай тэмцэх газрын Терроризмтой тэмцэх үйл ажиллагааны албаны дарга Ирфан Саидтай Монгол Улсад албан айлчлал хийж байх үед нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга албан уулзалт хийж, Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл өгч, цаашид Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын албан хаагчдын үр чадварыг дээшлүүлэх талаар хамтын ажиллагаагаа өргөжүүлэх тухай санал солилцжээ.

Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн албан хаагчид АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр Тайланд Улсын Бангкок хотноо “Олон улсын хууль сахиулах академи /ILEAV”-иас зохион байгуулсан “Trafficking in Persons” сургалтад хамрагджээ.

4.3. ХҮН ХУДАЛДААЛАХ, ТҮҮНТЭЙ ТӨСТЭЙ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА: АСУУДАЛ, ШИЙДЭЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн байдлыг тодорхойлох, цаашид авч хэрэгжүүлэх арга замыг эрэлхийлэх зорилгоор “Хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа: Асуудал, шийдэл хэлэлцүүлэг”-ийг 3 дахь жилдээ зохион байгуулжээ.

Хэлэлцүүлэгт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Улсын дээд шүүх, Нийслэл дэх Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Эрүүгийн хэргийн анан шатны шүүхийн шүүгчид, Улсын Ерөнхий прокурорын газар, Нийслэлийн прокурорын газрын прокурорууд, Цагдаагийн ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн албаны албан хаагчид, Хууль зүйн туслалцааны төв, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Монголын хуульчдын холбооны төлөөлөл оролцжээ.

Хэлэлцүүлгээр 2023 онд зохион байгуулагдсан хэлэлцүүлгийн үр дүнд гарсан зөвлөмжийн хэрэгжилтийн танилцуулга сонсож, Хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээ: харьцуулсан судалгаа, Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлага, Хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд анхаарвал зохих асуудал, “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам”-ын хэрэгжилт, анхаарах асуудал, цаашид авах арга хэмжээ, Хүүхдээс мэдүүлэг авах өрөөний ашиглалтын талаар танилцуулга мэдээлэл солилцлоо.

Энэ удаагийн хэлэлцүүлгээс дараах зөвлөмжийг гаргаж, холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлжээ. Үүнд:

- Хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хууль зүйн шинжийн давхцалыг арилгах зорилгоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Албадан бэлгийн харилцаанд оруулах” хэмээн томъёолж өөр зүйлд хуульчлах, мөн 12.3 дугаар зүйлд заасан хүндрүүлэх шинж буюу бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийг 13.1 дүгээр зүйлийн хүндрүүлэх шинжид хуульчлах талаар тодорхой саналыг хууль санаачлах эрх бүхий субъектэд уламжлах;
- Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Зорчих эрхийг хязгаарлах” гэсэн шинжийг хэрхэн ойлгох талаар тайлбар гаргуулахаар Улсын ерөнхий прокурорын газраас Улсын Дээд шүүхэд санал хүргүүлэх;
- Хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн улмаас хохирох эрсдэл бүхий зорилтот бүлгийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, нөлөөллийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч талууд, тэр дундаа шүүгч нарт Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тусгасан агуулгыг бүрэн гүйцэд ойлгуулах зорилгоор сургалт зохион байгуулах;
- Хууль сахиулах болон хил хамгаалах зэрэг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг шууд илрүүлэх боломжтой байгууллагын алба хаагчдад зориулж, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж, тогтоох зааварчилгааг боловсруулан батлуулах;
- Улсын өмгөөлөгч нарын хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн талаарх ойлголт, гэрч, хохирогчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад анхаарах асуудлын талаар мэдлэг, чадавхыг сайжруулах сургалтыг тогтмол зохион байгуулах. Ингэхдээ сургалтын хөтөлбөрийг боловсруулж, Монголын хуульчдын холбооны Сургалтын хороогоор магадлан итгэмжлүүлж, багц цаг тооцох сургалтын хэлбэрт шилжүүлэх;
- Хууль ёсны төлөөлөгчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч, хууль ёсны төлөөлөгчөөр ажиллах чиг үүргийн эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох, байнгын сургалтын суурь баазыг бий болгох;
- Төрийн бус байгууллагын дэргэд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа түр хамгаалах байрны санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, үйлчилгээний стандартыг батлуулах;
- Олон улсын туршлагад тулгуурласан, хохирогчоос ярилцлага, мэдүүлэг авах, тухайн ярилцлагын үр дүнг холбогдох байгууллагууд ашиглах нөхцөл боломжийг бүрдүүлсэн хохирогч хамгааллын нэгдсэн төвийг байгуулах талаар холбогдох байгууллагад санал хүргүүлж шийдвэрлүүлэх;



- Гэмт хэргийн улмаас сэтгэл санааны хохирол амссан хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээ хийж буй шүүх шинжилгээний байгууллагын хүний нөөцийг нэмэгдүүлэх, шүүх сэтгэцийн шинжээч эмч, сэтгэл зүйч нарт хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч хүүхэдтэй ажиллах, ярилцлага хийх, шинжээчийн дүгнэлт гаргах талаар мэргэшүүлэх сургалт зохион байгуулах зэргийг дурджээ.

4.4. САЛБАР ДУНДЫН ХАМТАРСАН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны даргын 2021 оны А/17 дугаар тушаалаар байгуулагдсан Салбар дундын хамтарсан баг 4 дэх жилдээ ажиллаж байна. Тайлант хугацаанд СДХБ-ийн ээлжит хуралдааныг нийт 2 удаа, дэд багийн 4 уулзалтыг зохион байгуулжээ.

- СДХБ-ийн гишүүдийг АНУ-ын туршлагатай мэргэжилтнүүдтэй холбон уулзуулах ганцаарчилсан менторшип хөтөлбөрийг хэрэгжүүлэн нийт 7 гишүүний 29 цагийн онлайн менторшип уулзалтыг зохион байгуулж дууссан байна.
- СДХБ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт ял шийтгэгдсэн этгээдийн хувийн мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх эрх зүйн зохицуулалт” хэлэлцүүлгийг 2024 оны 6 сарын 18-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлгээр бага насны хүүхдийг хүчиндэх, хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт ял шийтгэгдсэн этгээдүүдийн талаарх хувийн мэдээллийг агуулсан веб хуудас нээн тэднийг дахин энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах зорилгоор иргэд, олон нийтэд мэдээллийг ил болгох, тухайн мэдээллийн сангийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хууль эрх зүйн зохицуулалтыг хэлэлцэв.
- Салбар дундын хамтарсан багийн санаачилгаар Чингис хаан боомтод 2 ширхэг, Алтанбулаг боомтод 1 ширхэг ухаалаг самбарыг хүлээлгэн өгч, уг самбарт ашиглаж, иргэд олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор 10 төрлийн зурагт хуудас бэлтгэсэн. Түүнчлэн хилийн зарим боомтуудад хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх чиглэлээр мэдээлэл түгээх зорилгоор 50,000 ширхэг паспортын хавчуургыг бэлтгэж, тараасан байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр Салбар дундын хамтарсан багийн ажиллах эрх зүйн үндэс бий болсон. Иймд цаашид уг багийг хуульд зааснаар байгуулж, чиг үүргийг илүү тодорхой болгох шаардлагатай.

Өөрөөр хэлбэл салбар дундын хамтарсан багийн ажиллах журам болон үйл ажиллагааны зураглал бүхий баримт бичгийг олон улсын сайн туршлага, дотоодын нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад үндэслэн боловсруулах шаардлагатай юм.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон хохирогч хамгааллын талаарх хууль эрх зүйн орчин боловсронгуй болж, уялдаа холбоо сайжирч, мэргэжилтнүүдийн чадавх нэмэгдэн, олон нийтэд мэдээлэл түгээх ажил тогтмолжсон байна.

Хууль сахиулах байгууллагаас 2024 онд 27 холбогдогчтой 54 гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан ч ердөө 1 хэрэг нь л хохирогчийг гадаад улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болгосон тохиолдол, бусад нь бүгд дотоодод үйлдэгдсэн гэмт хэрэг байна. Бүртгэгдэн шалгагдсан бүх гэмт хэргийн хохирогчид нь эмэгтэй хүн байгаа анхаарч, эрэгтэй хохирогчийг илрүүлэх, таньж тогтоох ажиллагааг орхигдуулахгүй байх хэрэгтэй.

Гадаадын иргэн, харьяатын газраас авч хэрэгжүүлсэн хяналт шалгалтын мөрөөр гадаад улсын 7 иргэнийг албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэгт өртүүлж байсныг илрүүлж, хууль сахиулах байгууллагаас мөрдөн шалгах ажиллагаа явуулж эхэлсэн нь сайшаалтай байна.

Түүнчлэн Цагдаагийн байгууллагаас Гадаад харилцааны яам, Тагнуулын ерөнхий газартай хамтран 14 жилийн өмнө БНХАУ-д худалдаалагдаж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон 1 иргэнийг эх оронд эргүүлэн авчирчээ.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг тул гадаад улсын холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх, эх оронд нь эргүүлэн авчирч, хууль ёсны ашиг сонирхлыг нь хамгаалах нэн шаардлагатай байна.

Хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа боловч хохирогчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт хангалтгүй байгааг анхаарах шаардлагатай байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 7 хэргийн 17 шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 16 шүүгдэгчид 1 жилээс 12 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан нь Эрүүгийн хуулийн нэг зүйл, хэсэгт заасан гэмт хэрэг оногдуулах хорих ялын интервал их байгааг харуулж байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагаас хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч/үйлчлүүлэгчийг таньж тогтоож, илрүүлсэн тохиолдол өмнөх жилээс 30,8 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага үйл ажиллагаа зогссон, санхүүжилт тогтмол бус болсонтой холбоотой байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 215 дугаар тогтоол батлагдснаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих, санхүүжилт олгох эрх зүйн орчин бүрдсэн. Иймээс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх норматив зардлыг тогтоох шаардлагатай.



Цагдаагийн байгууллагын гэрч, хохирогчийг хамгаалах нэгжээс хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэгт өртсөн хохирогчид түр хамгаалан байрлуулах үйлчилгээ огт үзүүлээгүй байгааг анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэст хохирогчоор тогтоогдсон хохирогчийг хамгаалан байрлуулах, насанд хүрээгүй хүнийг Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийг гэмт хэрэгт өртсөн хохирогч хүүхдийг түр хамгаалан байрлуулах байранд байрлуулж хэвшүүлэх шаардлагатай байна.

Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр олон улсын төсөл, хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлснээр хууль сахиулах байгууллагын чадавх сайжирч, эрх зүйн орчин боловсронгуй болж, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа өргөжиж, урьдчилан сэргийлэх мэдээлэл түгээх тогтолцоо бүрэлдэн бэхжиж байна.

Цахим орчин дахь хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх шинэ арга хэрэгслийг нэвтрүүлж, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажлууд хийгджээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/49 дүгээр тушаалаар батлагдсан “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам”-ын хэрэгжилтийн талаар анх удаа хэлэлцүүлэг өрнүүлж, түүнийг өөрчлөх талаар санал боловсруулсан нь сайшаалтай байна.

Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үүрэг хүлээсэн байгууллагын албан хаагч, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр аян, төлөвлөгөөт арга хэмжээг авч хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрсэн боловч энэ нь нэг удаагийн шинжтэй, тодорхой хугацаанд өрнөөд дуусаж байгаа нь анхаарал татаж байна.

ЗӨВЛӨМЖ

1. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах үүрэг Ажлын хэсэг байгуулж, төслийг боловсруулах;
2. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг дагаж гарах Эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ хийх журам, Сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ хийх журам, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам, Салбар дундын хамтарсан багийн ажиллах журмыг яаралтай батлах;
3. Хүн худалдаалахтай тэмцэх дунд хугацааны хөтөлбөрийн төслийн эдийн засгийн тооцооллыг хийж, батлах;
4. Хууль зүйн туслалцааны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;
5. Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах, 12.3 дугаар зүйлд заасан Бэлгийн мөлжлөг, 13.3 дугаар зүйлд заасан Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн шинж, ялган зүйлчлэх талаар Улсын дээд шүүхийн тайлбар гаргуулах;
6. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/49 дүгээр тушаалаар батлагдсан “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам”-ын зарим зохицуулалтыг хууль тогтоомжид тусгах, зөвшөөрлийн системийг цахим хэлбэрт шилжүүлэх зэрэг арга хэмжээ авах;
7. Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүрээнд хийж буй Чингис хаан ОУНБ, Замын-Үүд, Алтанбулаг боомтод дамжин өнгөрөх ажиглалтын судалгааг цаашид тогтмолжуулах эрх зүйн болон зохион байгуулалтын боломжийг бий болгох;
8. Хүн худалдаалах гэмт хэргийн эрэгтэй хохирогч, албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэгт өртсөн хохирогчийг таньж тогтоох, илрүүлэх заавар гаргах, зааврыг холбогдох мэргэжлийн бүлгүүдэд алба хаагч, хөдөлмөрийн байцаагчдад таниулах сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах;
9. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний хувьсах зардлыг тооцох аргачлалыг боловсруулах, батлуулах, улмаар улсын төсөвт суулгах;
10. Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх/хөдөлмөр мөлжлөгийн гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээний санхүүжилтийг бодитоор нэмэгдүүлэх;
11. Хүн худалдаалах гэмт хэргийн чиглэлээр явагдаж буй сургалтын залгамж чанарыг хадгалж, хууль сахиулах, нийгмийн хамгааллын байгууллагуудын сургалтын системд нэвтрүүлж, сургагч багшаар бэлтгэгдсэн 38 алба хаагчид тулгуурлан сургалтыг жил бүр давтамжтайгаар зохион байгуулах;
12. Олон улсын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх явцад бий болсон сайн туршлагыг цаашид тогтвортойгоор ашиглах, үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд анхаарах;
13. Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж буй аян, нэгдсэн арга хэмжээг тогтвортой бөгөөд урт хугацаанд хэрэгжүүлэх;
14. Хууль сахиулах байгууллагаас хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг шинжилгээ хийлгэж, тогтоолгох, мөн сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн сэргээх, сэтгэл заслын эмчилгээнд зарцуулах зардлыг тогтоосон нотлох баримтыг мөрдөн шалгах ажиллагааны явцад цуглуулж, мөрдөн шалгах ажиллагааны явцад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажиллагааг улам сайжруулах шаардлагатай зэрэг болно.

